ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН: “ӨГӨӨЖ ИХ ОРД” ХХК

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ӨГӨӨЖ ИХ ОРД” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “УРТ ГОЗГОРЫН ХӨНДИЙН ЦАГААН ТУГАЛГАНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

/Регистрийн дугаар: 6496148/



УЛААНБААТАР ХОТ

2026 ОН

“ӨГӨӨЖ ИХ ОРД” ХХК

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ “ӨГӨӨЖ ИХ ОРД” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ УРТ ГОЗГОРЫН ЦАГААН ТУГАЛГАНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2026 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020756

Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 6496148

Төлөвлөгөөтэй танилцсан:

“ӨГӨӨЖ ИХ ОРД” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ **Н.ДАШНАМЖИЛ**

Төлөвлөгөө боловсруулсан:

“ӨГӨӨЖ ИХ ОРД” ХХК-ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН **Б.ХОНГОРЗУЛ**

Улаанбаатар хот

2026 он

АГУУЛГА

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 4

1.1.Төслийн талаарх мэдээлэл 4
1.2 Ордын ерөнхий мэдээлэл 4
1.3 2026 оны уулын ажлын төлөвлөлт 8
1.3.1.Ил уурхайн нээлт болон ашиглалтын дараалал 9
1.3.2.Овоолго 10
1.4. Уурхайн усан хангамж 10
1.5. Ерөнхий мэдээлэл 10
1.6. Цахилгаан хангамж 11
1.7.Уурхайн гадаад цахилгаан хангамж 12
4.2.4. Уурхайн дотоод цахилгаан хангамж 13
4.6. Засварын газар 13

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ 14

2.1. Ерөнхий зүйл 14
2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн орчин 15

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТ 16

3.1. Төслийн байгаль орчны удирдлагын тогтолцоо 16

БҮЛЭГ 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА 17

2.1. Уур амьсгал өнөөгийн төлөв байдал 17
2.2. Физик-газарзүй 18
2.3. Газрын гадарга, хэвлий өнөөгийн төлөв байдал 18
2.4. Төслийн талбайн гадаргын усны төлөв байдал 18
2.5. Хөрсөн бүрхэвч өнөөгийн төлөв байдал: 19
2.6. Ургамлан бүрхэвч өнөөгийн төлөв байдал 19
2.7. Төслийн талбай орчмын амьтны аймаг 20

БҮЛЭГ 5. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 21

3.1.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл 23
3.2.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл 24
3.3. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл 26

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ 32

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 34

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 38

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ , ТЭРБУМ МОДНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 39

7.1 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах 39
7.2 Тэр бум мод үнэдсэний хөтөлбөрийн хүрээнд 40

БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 41

БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ 41

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 42

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ 44

БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР 46

БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ 51

БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ 52

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ 53

ХАВСРАЛТ 57

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд 4
Хүснэгт 2. Техник - Эдийн засгийн үндсэн үзүүлэлт 6
Хүснэгт 4. Ил уурхайн ажиллах горим 8
Хүснэгт 5. Ил уурхайн үндсэн хэмжээснүүд 9
Хүснэгт 6. Овоолгын үндсэн үзүүлэлтүүд /сийрэгжилт тооцсон/ 10
Хүснэгт 7. Уурхайд хэрэглэгдэх усны зарцуулалтын тооцоо 10
Хүснэгт 9. . Болзошгүй нөлөөллийн үнэлгээний Леопольдын матриц 21
Хүснэгт 10. Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээ 24
ХХүснэгт 11. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ 24
Хүснэгт 12. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ 25
Хүснэгт 13. Агаарт үзүүлэх нөлөөллийн эрчим 27
Хүснэгт 14. Амьтны аймагт нөлөөлөх байдлын 28
Хүснэгт 15. Болзошгүй эрэг нөлөөлөл 29
Хүснэгт 16. Болзошгүй сөрөг нөлөөлөл 30
Хүснэгт 17. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ 30
Хүснэгт 18. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгтгэл 31
Хүснэгт 19. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө 35
Хүснэгт 20.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө 38
Хүснэгт 21. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 39

Хүснэгт 22. Тэрбум модны зардал 40
Хүснэгт 23.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө 41
Хүснэгт 24. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө 42
Хүснэгт 25. *Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах буурууллах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө* 44
Хүснэгт 26. 2026 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр 48
Хүснэгт 27. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө 51
Хүснэгт 28. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа 52
Хүснэгт 29. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт 53

Зургийн жагсаалт

Зураг 1. Төслийн талбайн байршлын ерөнхий зураг, районы агаар, сансрын зураг 5
Зураг 2. Төслийн талбайн фото зураг 6
Зураг 4. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мод тарих талбай 39
Зураг 5. Тэрбум модны хүрээнд мод тарих талбай 40
Зураг 6. Төслийн талбай дахь мониторингийн цэг 47

БҮЛЭГ 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1.Төслийн талаарх мэдээлэл

Төслийн нэр: MV-020756 тоот тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг ил аргаар ашиглах төсөл.

Төслийн зорилго: Монгол улсад мөрдөгдөж байгаа холбогдох хууль, дүрэм эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурласан бөгөөд орд газр ыг байгаль орчинд хал багатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай технологиор хаягдалгүй ашиглахад зорилго оршино.

Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл: “Өгөөж их орд” ХХК нь Монгол улсын 9011812908 тоот улсын бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй 6496148 тоот регистрийн дугаартай байна.

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, олимпийн, 19а, Шангри-Ла оффис 11 давхар 1107-1108 тоот, Утас1: 99966101

Түсгай зөвшөөрөл: АМГТГ-ын 2017 оны 01 сарын 19-ний өдрийн тусгай зөвшөөрөл

Төслийн байршил: Төслийн талбай болох Урт гозгорын цагаан тугалганы шороон ордын тусгай зөвшөөрлийн талбай нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 70 км, Эрдэнэ сумын төвөөс баруун урагш 25 км, Өвөр жанчивлангийн рашаан сувиллаас баруун тийш 7 км зайд тус тус оршино.

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд

№	Тусгай зөвшөөрлийн дугаар	Талбайн хэмжээ, га	Уртраг	Өргөрөг
1	MV-020756	243.4	$107^0$34’00.11’’	$47^0$34’07,51’’
2			$107^0$34’00.11’’	$47^0$35’11,76’’
3			$107^0$33’01.42’’	$47^0$35’11,76’’
4			$107^0$33’01.42’’	$47^0$34’07.51’’

1.2 Ордын ерөнхий мэдээлэл

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших MV-020756 тоот тусгай зөвшөөрөл бүхий Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг ЭБЭХ-ий сайдын 2012 оны 04-р сарын 17-ны өдрийн 074 тоот тушаалаар батлагдсан "Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам", Уул уурхайн сайдын 2015 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 203 дугаар тушаал зэрэг материалыг үндэслэн уул уурхайн зураг төсөл, судалгааны үйлчилгээ эрхэлдэг “Ляпислазурь эрдэнэ” ХХК-ийн инженерүүд Монгол улсын зөвлөх инженер Г.Сандагдоржийн зөвлөснөөр гүйцэтгүүлсэн байна.

“Зөв газар элемент” ХХК нь Урт гозгорын цагаан тугалганы шороон ордод 2016 онд

хайгуулын ажил гүйцэтгэн, ордын нөөцийг бодитой болон боломжтой зэргээр B+C=57.44 тн-оор Улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байна..


Төслийн талбай болох Урт гозгорын цагаан тугалганы шороон ордын тусгай зөвшөөрлийн талбай нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 70 км, Эрдэнэ сумын төвөөс баруун урагш 25 км, Өвөр жанчивлангийн рашаан сувилалаас баруун тийш 7 км зайд тус тус оршино.

“Зөв газар элемент” ХХК-ийн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дах тунгалагт нэртэй 194.12 гектар талбай бүхий MV-020756 тоот тусгай зөвшөөрлийг TR-009533 дугаарт бүртгэн хянаж үзээд Ашигт малтмалын тухай хуулийн 49-дүгээр зүйлийн 49.3 дах хэсэгт заасныг үндэслэн Кадастрын хэлтсийн даргын 2025 оны 08-дугаар сарын 07-ны өдрийн 440 дугаар шийдвэрээр /,тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүд хэвээр/ “Өгөөж их орд” ХХК-д шилжүүлснийг бүртгэж тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглэгээ хийсэн байна.

Иймээс Төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тдотогол хийлгэх эрхзүйн шаардлага үүсэн байна.

Төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОУАӨЯ-ны Байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт чиглэл хуваарийн дагуу мөн Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Засгийн газрын 2023 оны 02-дугаар сарын 08-ны өдрийн 58 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам”, зэрэг эрхзүйн баримтуудыг үндэслэж “Дойтын булаг” ХХК хийж гүйцэтгэв.

Зураг 1. Төслийн талбайн байршлын ерөнхий зураг, районы агаар, сансрын зураг



Зураг 2. Төслийн талбайн фото зураг



Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт “Өгөөж их орд” ХХК-ийн MV-020756 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах төсөлд холбогдолтой анхдагч дата материал цуглуулах танилцах төслийн талбайд суурь судалгаа хийх мөн төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг тодорхойлж, үнэлгээ өгөх, оновчтой хувилбаруудыг боловсруулах, сөрөг нөлөөллийг бууруулах зохистой арга хэмжээ, түүний менежментийг төлөвлөх, мониторингийн үзүүлэлтийг тодорхойлох, тайлан боловсруулах, тайланг орон нутгийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх зэрэг дарааллын дагуу энэхүү байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний ажил гүйцэтгэгдсэн болно.

Хүснэгт 2. Техник - Эдийн засгийн үндсэн үзүүлэлт

№	Үзүүлэлтүүд	Тодорхойлолтууд
1	Уурхайн нэр	Урт гозгор
2	Ордын нэр ба тусгай зөвшөөрлийн дугаар	Урт гозгорын цагаан тугалганы шороон орд MV-020756
Уул техникийн нөхцөлийн талаар		
1	Ордын батлагдсан нөөц	B+C= 11.2 кг /химийн цэвэр/
5	Ил уурхайн хүрээн дэх үйлдвэрлэлийн нөөц	B’=9.32 кг /химийн цэвэр/
6	Элсний давхаргын зузаан	1.1 м
7	Хучаас хөрсний зузаан	1.2 м
8	Ашиглах арга ба хугацаа	Ил аргаар 3 жил
9	Ашиглалтын систем	Дотоод овоолготой, авто тээвэртэй
10	Шимт хөрс хуулалт	4.95 мян.м3
11	Доголын налуугийн өнцөг	474.07 мян.м3
12	Ажлын талбайн өргөн	33.68 мян.м3

13	**Хөрс хуулалт**		**935 м**
14	**Элс олборлолт**		**1м**
15	**Уурхайн өндөржилт (далайн түвшнээс дээш)**		**1.1м**
	Доголын налуугийн өнцөг		**2 м3-ийн утгуурын багтаамжтай Komatsu маркийн урвуу утгуурт экскаватор**
	Металл авалт		**20 тн даацтай HOWO маркийн автосамосвалууд**
	Бүтээгдэхүүн гаргалт	**Баяжмалын хэмжээ**	**3.5 м3-н шанаганы багтаамжтай Komatsu WA430 маркийн утгуурт ачигч**
		Баяжмал дахь SnO2 (шлихээр)	**Геомаш-40 угаах төхөөрөмж**
		Баяжмал дахь Sn (хими цэвэр)	**6s-7.6 маркийн баяжуулах ширээ**
	Уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжүүд		**Эргэлтийн усны насосууд**
	Цахилгаан хангамж		**Налайх дүүрэг Эрдэнэ сум Өвөр жанчивлан руу татсан 35 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаас “Гурван төхөм” ХХК-ний алтны шороон орд хүртэлх 10 кВ-ын шугамнаас Унагадын орд хүртэл 10 кВ-ын шугам татаж цахилгаан эрчим хүчээр хангана.**

Хөрс хуулалтын технологи: Хөрс хуулалтын ажил нь үржил шимт хөрсийг урьдчилан хуулах болон үндсэн хөрсийг хуулах гэсэн үндсэн 2 шатлалтай явагдана.

Нэгдүгээр үе шат: Уурхайн уулын ажлын ахилт, өрнөлтэй уялдуулан тухайн жилд ашиглалтад өртөх талбайн болон хөрсний гадаад овоолгод дарагдах талбайн өнгөн хөрсийг уг бүс нутгийн хөрсний шимт болон шилжилтийн үеийн зузаанаас хамааруулан 20 см хүртэлх зузаантайгаар хуулах бөгөөд уурхайн эцсийн хүрээний гадна талд салхины шууд нөлөөллөөс далд нөмөр газар овоолго үүсгэн хураана. Уг ордын уурхайн ашиглалтад өртөх талбайгаас нийт 137.8 мян.м3 шимт хөрсийг хуулна. Мөн үүнээс гадна үйлдвэрлэлийн зориулалтаар уурхайн болон зам талбай барилга байгууламжид өртөн эвдэгдэх талбайнуудын үржил шимт хөрсийг 20 см зузаантайгаар урьдчилан хуулж хадгална.

Хоёрдугаар үе шат: Ил уурхайн хуулах хөрсийг өрөмдлөг, тэсэлгээгээр сийрэгжүүлэх шаардлагатай юм. Хөрс хуулалтын ажлын доголын өндөр нь 5 м байх бөгөөд ажлын доголын хажуугийн өнцөг нь тухайн доголын чулуулгийн тогтворжилтоос хамаарч 60-65 градус байна. Хөрс хуулалтын доголыг уурхайн хананд хаах үед доголын өндөр 10 м байна. Ингэж тусгайлан хадгалсан үржил шимт хөрсийг уурхайн үйл ажиллагаа дууссаны дараагаар уг эвдэгдсэн талбайд нөхөн сэргээлтийн ажил хийхэд ашиглана. Шимт хөрсний овоолгын өндөр нь 5 м-ээс өндөр байж болохгүй. Уг ажилд MNS 5916:2008: Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт гэсэн стандартыг мөрдлөг болгон ажиллана.

Олборлолтын технологи: Ил уурхайн хүдрийн бат бөхийн итгэлцүүр нь проф. М.М.Протодъяконовын ангиллаар дунджаар 8-9 учир өрөмдлөг, тэсэлгээгээр сийрэгжүүлж экскаватораар ухаж ачин автосамосвалаар тээвэрлэж уурхайн гарц траншейн амнаас баяжуулах үйлдвэрийн дэргэдэх ангилан ялгах талбай хүртэл тээвэрлэнэ. Олборлолтын ажлын доголын өндөр нь 5 м, ажлын бус доголын өндрийг 10м, ажлын доголын хажуугийн өнцгийг чулуулгийн физик-механик шинж чанараас нь хамааруулан 60-65 градусаар төлөвлөсөн Урт гозгорын хөндийн хэсэг цагаан тугалганы шороон ордын хөрсний давхаргын зузаан
0.5-1.1 м, элсний давхаргын зузаан 0.5-1.1 м байх ба тусгай зөвшөөрлийн хилээс хамаарч олборлолтод өртөхгүй нөөц байгаа тул үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо уурхайн хүрээний гаднах хаягдал болон ашиглалтын үеийн бохирдолт зэргийн хэмжээг үндэслэн тооцов.
Олборлолтын үеийн бохирдолтыг элсний давхаргын тааз, ул, хажуу хананаас нэмэгдэх хоосон чулуулгийн хэмжээг блок тус бүрээр тус тус тооцоолж ордын ашиглалтын нөөцийн тооцоог гүйцэтгэв. Ашиглалтын үеийн дундаж бохирдол 13.56 % байна. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор төсөл хэрэгжих хугацаанд ордоос нийт үржил шимт хөрс 17.5 мян.м3, үндсэн хөрс 134.19 мян.м3 (сийрэгжилт тооцоогүй) тус тус хуулах бол дунджаар SnO2 445.91 г/м3, FeTiO3 49.24 г/м3 агуулга бүхий 167.36 мян.м3 элс /элсэн дэх металлын хэмжээ шлихээр SnO2 74.63 тн, FeTiO3 8.24 тн олборлоно.

1.3 2026 оны уулын ажлын төлөвлөлт

2026 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөөг 6-В, 7-В, 8-В хэсэгшлийн хэмжээнд хөрс 92.52 мян.м куб, элсний хэмжээ 82.02 мян.м куб нийт 167.69 мян.м куб уулын ажлыг явуулах бөгөөд 65.0 мян.м куб элсийг баяжуулж 17.02 мян.м куб элсний овоолгыг үүсгэнэ.
Урт гозгорын хөндийн хэсэг цагаан тугалганы шороон ордын нөөц тогтоон бодсон 6-В, 7-В, 8-В блокуудын нөөцийг ашиглах бөгөөд MV-020756 тоот ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл бүхий талбайн хүрээнд онцгой хамгаалалтын бүс байхгүй. Дээрх блокуудад олборлолт явуулах ил уурхай нь хамгаалалтын бүс болон талбайн хилээр хязгаарлагдахгүй.
Урт гозгорын хөндийн хэсэг цагаан тугалганы шороон ордын хөрсний давхаргын зузаан 1.34 м, элсний давхаргын зузаан 1.09 м байх ба үйлдвэрлэлийн нөөцийг тооцохдоо ашиглалтын хаягдалгүйгээр бохирдолтыг нэмж тооцов. Олборлолтын үеийн бохирдолтыг элсний давхаргын тааз, ул, хажуу хананаас нэмэгдэх хоосон чулуулгийн хэмжээг блок тус бүрээр тус тус тооцоолж ордын ашиглалтын нөөцийн тооцоог гүйцэтгэв. Ашиглалтын үеийн дундаж бохирдол 14.24 % байна.
Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор 2026 онд ордоос нийт үржил шимт хөрс 19.9 мян.м3, үндсэн хөрс 72.55 мян.м3 (сийрэгжилт тооцоогүй) тус тус хуулах бол дунджаар SnO2 445.91 г/м3, FeTiO3 49.24 г/м3 агуулга бүхий 82.02 мян.м3 элс, элсэн дэх металлын хэмжээ шлихээр SnO2 39.54 тн, FeTiO3 3.82 тн олборлоно.
2026 онд 92.52 мян.м3 хөрс хуулж, 82.02 мян.м3 элс олборлохоор төлөвлөлөө.

Хүснэгт 3. Ил уурхайн ажиллах горим

№	Үндсэн хэмжигдэхүүнүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Жилийн хуанлийн хоног /дулааны улиралд/	хоног	101
2	Уурхайн бэлтгэл ажил	хоног	10
3	Баяр ёслолын үеийн амралтын хоног	хоног	2
4	Цаг агаарын хүндрэл	хоног	8
5	Уурхайн ажиллах хоног	хоног	81
6	Хоногт ажиллах ээлжийн тоо /ил уурхай/	-	2
7	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10

Тус ордыг ашиглах ашиглалтын нийт хугацаанд магадалсан В’ зэрэглэлийн блокуудад хөрс хуулалт болон элс олборлолтын ажлыг хийж гүйцэтгэнэ. Ил уурхайгаар ашиглалт явуулах үед хуулах хөрсний зузаан дунджаар 1.34 м, үүнээс үржил шимт хөрсний зузаан 0.3 м, ашигт давхаргын зузаан нь дунджаар 1.09 м тус тус байна.

Иймд хөрс хуулалт болон элс олборлолтын ажилд ажиллах техник тоног төхөөрөмжүүдийг ил уурхайн үндсэн хэмжээснүүдэд тулгуурлан сонгоно. Ил уурхайн үндсэн хэмжигдэхүүнийг дараах байдлаар сонгож байна.

Хүснэгт 4. Ил уурхайн үндсэн хэмжээснүүд

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоон үзүүлэлтүүд
1	Ил уурхайн гүн	м	2.5
2	Ил уурхайн амсрын өргөн	м	160
3	Ил уурхайн амсрын урт	м	270
4	Ил уурхайн хажуугийн өнцөг	градус	41-46
5	Хөрс хуулалтын ажлын доголын өндөр	м	1
6	Элс олборлолтын ажлын доголын өндөр	м	1.2
7	Элс олборлолтын доголын налуугийн өнцөг	градус	45
8	Хөрс хуулалтын доголын хажуугийн өнцөг	градус	55
9	Ажлын бус доголын аюулгүйн тавцангийн өргөн	м	2
10	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага өргөн	м	100
11	Ил уурхайн улны хэсгийн хамгийн бага урт	м	240
12	Ажлын талбайн өргөн	м	30

Ордыг ил уурхайн аргаар ашиглах ба ил уурхайн хөрс хуулалтын ажлыг авто тээвэртэй дотоод овоолготой ашиглалтын системээр гүйцэтгэнэ. Уулын ажил явуулахын өмнө үржил шимт хөрсийг 0.3 метрийн зузаантай утгуурт ачигчийн тусламжтайгаар түрэлт хийж уурхайн хүрээн гадна байршуулна. Хөрс хуулалтын ажлыг дотоод овоолго хийх орон зай бий болох хүртэл тус ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай дотор гадаад овоолгод байршуулна. Ил уурхайн ухашыг нөхөн дүүргэх дотоод овоолго хийх орон зай бий болсон үеэс ордыг ашиглаж дуустал дотоод овоолго хийнэ.

Элс олборлолтын ажлыг авто тээвэртэй ил уурхайн ашиглалтын системээр гүйцэтгэнэ. Элс олборлолтын ажлыг экскаватор болон автосамосвалын хослолоор ухаж ачин тээвэрлэх ба олборлосон элсийг угаан баяжуулах тоног төхөөрөмжийн дэргэд байрлах элсний овоолго руу тээвэрлэж хүргэнэ. Тус ордын ашиглалтын үндсэн үйл ажиллагаа нь:

- ✓ Үржил шимт хөрс хуулах
- ✓ Хөрс хуулалтын ажил
- ✓ Элс олборлолтын ажил
- ✓ Элс угаан баяжуулах
- ✓ Баяжуулах хэсгээс гарсан эфель, галийг хоосон орон зайд буцааж хийх
- ✓ Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх зэрэг болно.

1.3.1.Ил уурхайн нээлт болон ашиглалтын дараалал

Ил уурхайг нээх: Ил уурхайг нээхдээ ашигт малтмалын гарш ойр эсвэл тээврийн зай ойр байх нөхцөлүүдийн харгалзана. Тус ордын хувьд хөрсний дотоод овоолготой ашиглалтын системтэй тул боломжтой нөөцийг зэргийн хамгийн захын блокоос ашиглалт эхлэх нь илүү тохиромжтой В’-6 блокоос олборлолт эхэлнэ. Мөн газрын гадаргын хувьд тус блок нь 1645-р түвшинд буюу хамгийн нам дор хэсэгт байгаа нь элсний давхаргад хамгийн ойр, угаан баяжуулах хэсэгтэй ойр гэх мэт давуу талтай.

***Үржил шимт хөрс хуулалт*:** Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3 м-ээс ихгүй зузаантайгаар хуулна. Үржил шимт хөрсийг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил

уурхайн олборлолтын талбайгаас гадна 4 градусын налуутайгаар түрэлт хийж хадгалах, арчлах, тухай стандартын дагуу хадгална.

Үндсэн хөрс хуулалтын ажил: Экскаватороор хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж ашигласан орон зайд дотоод овоолгод хураана. Хөрс хуулалтын ажлын доголын өндөр 1 м өндөртэй байна. Хөрс хуулалтынажилд 1.5 $м^3$-ын утгуурын багтаамжтай АНУ-д үйлдвэрлэсэн Komatsu PC300-8 маркийн гидравлик экскаватор болон 20 тн даацтай HOWO маркийн БНХАУ-д үйлдвэрлэсэн автосамосвалыг тус тус ашиглана.

1.3.2.Овоолго

Орд нь хэвтээ уналтай тул дотоод овоолготой ашиглалтын систем хэрэглэнэ. Ордын ашиглалтын явцад уулын ажил явагдахаар төлөвлөгдсөн талбайн өнгөн хөрс буюу шимт хөрсийг 0.3 м-ийн зузаантайгаар урьдчилан хуулна. Шимт хөрс хуулах ажилд утгуурт ачигч түрэлт хийн уурхайн гадна байрлуулан хураана. Овоолгын өндөр 0.5-1 м хүртэлх өндөртэй байх ба тогтвортой хажуугийн өнцөг 4 градус байна. Шимт хөрсний овоолгыг аль болох хуурай сэрүүний улиралд байгуулах нь тохиромжтой ба нам дор газар сонгох нь зүйтэй.

Уурхайн ашиглалтын нийт хугацаанд 19.97 мян.$м^3$ үржил шимт хөрс, 72.55 мян.$м^3$ үндсэн хөрс хуулалтын ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 5. Овоолгын үндсэн үзүүлэлтүүд /сийрэгжилт тооцсон/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Талбай, га
1	Хөрсний дотоод овоолго	мян.$м^3$	72.55	2.9
3	Шимт хөрсний овоолго	мян.$м^3$	19.97	1.9

Шимт хөрс хуулах ажилд болон олборлосон элсийг угаан баяжуулах хэсгийн дэргэд овоолго үүсгэн хураах ба Komatsu WA430 маркийн утгуурт ачигчаар угаах төхөөрөмж рүү хийх ба угаах төхөөрөмжөөс гөрсөн эфель, галийг утгуурт ачигчаар элс тээвэрлэсэн автосамосвалуудад ачна.

1.4. Уурхайн усан хангамж

Тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд газрын гадаргын ус, гол нуур цөөрөм ховор боловч гүний уст давхарга элбэг тохиолдох тул уурхайн болон баяжуулах хэсгийн хэрэглэгчдийн усны хэрэгцээг гүний худгийн усаар хангана. Өдөрт 1 хүнд ногдох усны хэрэгцээ 150 литр байна. Уурхайн баяжуулах хэсэгт ашиглах усыг тунаах нуур ашиглаж бохир усны 75%-ийг эргүүлэн ашиглана.

Хүснэгт 6. Уурхайд хэрэглэгдэх усны зарцуулалтын тооцоо

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Технологийн замын тоосжилт дарах	$м^3$/хоног	7
2	Унд ахуйн зориулалтаар	$м^3$/хоног	6.87
3	Бусад хэрэгцээ	$м^3$/хоног	4.78
3	Нийт	$м^3$/хоног	16.65

1.5. Ерөнхий мэдээлэл

Тус орд нь засаг захиргаа нэгжийн хувьд Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших ба дэд бүтэц, зам харилцаа харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт хамрагддаг. Үйлдвэрийн бүрэлдэхүүн нь дараах хэсгүүдээс бүрдэнэ.

- Ил уурхай
- Баяжуулах үйлдвэр
- Захиргаа, ажилчдын байрууд
- Цахилгаан хангамж /ТЭХНС/
- Усан хангамж /Гүний худаг/
- Засварын газар
- Хоолны газар /Сэндвич барилга/
- Уурхай орчмын замууд зэрэг багтана.


Уг төсөлд эдгээр барилга байгууламж болон үйлдвэрлэлийн зориулалттай объектуудын холбогдох зардлыг хөрөнгө оруулалтын зардалд тусгасан болно. Хүний нөөцийн хувьд орон нутгийн ажилчдыг ажлын байраар хангах бодлогыг эхний ээлжид авч үзэх ба орон нутгийн иргэдэд сургалтын тэтгэлэг олгох, мэргэжил дээшлүүлэх сургалт зохион байгуулах, дадлагажуулах хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаж байна.

1.6. Цахилгаан хангамж

Ил уурхай болон угаан баяжуулах үйлдвэрт шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн цахилгаан хангамжийн үр ашигтай схемийг бий болгохын тулд уурхай болон баяжуулах үйлдвэрийн ажлын горим, технологи, механикжуулалт, цахилгаанжуулалтын бүхий л онцлогуудыг тусгана.


Уурхай болон баяжуулах үйлдвэр нь олон тооны цахилгаан хэрэглэгчидтэй бөгөөд тэдгээрийн суурилагдсан чадал нь ордын ашиглалтын нөөц, ордын байршил, уул техникийн нөхцөл, уурхайн хүчин чадал, үйлдвэрлэлийн процессын механикжуулалт зэргээс хамаарна.

Тус ордын уурхай болон баяжуулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг Улаанбаатар Налайх дүүрэг Эрдэнэ сум Өвөр жанчивлан руу татсан 35 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаас “Гурван төхөм” ХХК-ний алтны шороон орд хүртэл татсан 10 кВ-ын шугам ордын дэргэдүүр өнгөрдөг бөгөөд дээрх шугамаас уурхай хүртэл 500 м зайд 10 кВ-ын цахилгааны шугам татаж, 400 кВА хүчин чадалтай 10/0.4кВ-ын трансформатораас цахилгаан хэрэглэгчдийг эрчим хүчээр хангана



1.7.Уурхайн гадаад цахилгаан хангамж

Хүчний трансформаторын тооцооны чадлаас үндэслэн уурхайн бүх цахилгаан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор 10/0.4 кВ-ын 400 кВА-гийн чадалтай ТМ-400/0.4 маркийн трансформатор сонгож авав. Тус уурхайг төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон учир нэмэлт өндөр хүчдэлийн агаарын шугам татах шаардлагагүй гэж үзэн уурхайн тосгон зэргийн тэжээж байгаа 10 кВ-ын өндөр хүчдэлийн агаарын шугамаас үргэлжлүүлэн ажиллан уурхайн хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангана.



1-р зураг. Уурхайн гадаад цахилгаан хангамжийн зарчмын схем

4.2.4. Уурхайн дотоод цахилгаан хангамж

Ил уурхай, баяжуулах үйлдвэр, засвар механикийн цех, уурхайн тосгон зэрэг цахилгаан хэрэглэгчид нь 10/0.4 кВ-ын ерөнхий бууруулах дэд станцаас өөр өөрийн 10/0.4кВ-ын трансформаторын дэд станцуудаар дамжин цахилгаан эрчим хүчээр хангагдана.

Уурхайн захиргаа, ажилчдын байр хоолны газар, засварын газар, шатахуун түгээх станц зэрэг газруудын цахилгаан хэрэглэгчид нь 0.4 кВ-ын холболт болон кабель шугамуудаар 380/220 В-ын хүчдэлээр тэжээгдэнэ.

4.6. Засварын газар

Уурхайн тоног төхөөрөмжийн засвар, техникийн үйлчилгээний газар нь уулын механик тоног төхөөрөмж, авто тээврийн болон бусад тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг хангахын тулд урсгал засвар, техникийн үйлчилгээ хийх, ашиглалт засварын хэрэгцээнд зориулсан материал, сэлбэг, тос, түлш зэргийг хүлээн авах, хадгалах зэрэг ажлыг гүйцэтгэнэ.

Засварын газар: Уурхайн тосгоны дэргэд байрлах машин механизмын тоног төхөөрөмжийг засварлах, хуучин сэлбэгийг сэргээн засварлах, урсгал засварын ажлыг хийж гүйцэтгэхэд оршино. Нэгдсэн

засварын цехийн тоног төхөөрөмжүүдийн засвар үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмжийг иж бүрнээр сонгосон байна. Үүнд:

• Токарийн суурь машин • Өндөр даралтын шланк базагч • Өрмийн суурь машин • Суурин гидравлик насос • Суурин точил		• Аккумлятор цэнэглэгч • Гагнуурын аппарат • Хийн гагнуур • Керосин зүсүүр тус тус байна.

БҮЛЭГ 2. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

2.1. Ерөнхий зүйл

Хөдөлмөрийн процесст хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалж, аюулгүй ажиллагааг хангаж чадах нөхцөлийг бий болгоход чиглэсэн хууль тогтоомж, нийгэм эдийн засаг зохион байгуулалт, техник, ариун цэвэр, эрүүл ахуйн цогцолбор арга хэмжээ авах нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн арга хэмжээний гол зорилго юм. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандарт боловсруулан мөрдөж, дотоод хяналт шалгалт болон зааварчилгааг тогтмолжуулснаар аюул осолгүй ажиллах болно. Цаашид хөдөлмөр хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм заавар журам боловсруулж бүх ажилчдад танилцуулахаас гадна доорх дүрэм, зааврыг үйлдвэрлэлд мөрдлөг болгон ажиллавал зохино.

- Ажлын байрны дуу чимээ шуугианы хэмжээ нь УСТ-12-1-008-85 /MNS/-д заасан шаардлагыг хангасан байна.
- Дуу чимээ шуугиантай орчинд ажиллагсдад чихэвч хэрэглүүлэх ба ажлын дэглэм тогтоон ажиллуулах зэргээр чих дүлийрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Ажлын байранд байгалийн гэрэлтүүлгийн итгэлцүүр 1.5 хувиас багагүй байна. Гэрэлтүүлэг нь ажлын талбарт жигд тархсан гялбалт үүсэхгүй байх шаардлагатай ба гэрэлтүүлэгчийн үүсвэрийг тогтмол хугацаанд байнга цэвэрлэж байх
- Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон материалаар хийгдсэн, хэв загвар нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан байна
- Ажлын тусгай хувцасны чанарын үзүүлэлтийн жагсаалт /УСТ-0012.4016.89 MNS/-ыг баримтлан ажлын хувцас хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацааг баталсан тогтоол шийдвэр гаргах ёстой. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг шаардлагын дагуу угаах, ариутгах цэвэрлэх нөхцөл боломжийг ажил олгогч хангасан байвал зохино.

Хөдөлмөр эрхлэх аюулгүй арга ажиллагаанд сургах, сургалт явуулах талаар зааварчилга өгөх тухайн мэргэжлийг эзэмшсэн эсэх болон ажлын дадлага туршлагыг үл харгалзан бүх ажилчдыг хамруулан зохион байгуулна.

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хамруулан MNS-OSHAS 18001:2012 тоот монгол улсын стандартчиллын үндэсний зөвлөлийн 2012 оны 11-р сарын 22 өдрийн 27 дугаар тогтоолоор баталсан байдаг. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үнэлгээ /ХЭМАБ/

бүхий аж ахуй нэгж байгууллагуудтай холбоотой өөрсдийн эрсдэлийг хянаж, үйл ажиллагаагаа сайжруулах боломжийг бүрдүүлэх ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны шаардлагыг тогтоосон байна.

2.2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль эрх зүйн орчин

1-р хүснэгт. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын жагсаалт

№	Стандартын нэр	Тэмдэглэгээ
1	ХАБЭА. Нэр томьёо, тодорхойлолт	MNS 4967 : 2000
2	ХАБЭА. Ерөнхий шаардлага	MNS 4968 : 2000
3	ХАБЭА. Сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм	MNS 4969 : 2000
4	ХАБЭА. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага	MNS 4990 : 2000
5	ХАБЭА. Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ	MNS 5080 : 2001
6	ХАБЭА. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага	MNS 5105 : 2001
7	ХАБЭА, Хөдөлмөрийн физиологи, мэдрэл сэтгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтүүдийн норм	MNS 5106 : 2001
8	ХАБЭА, Хөдөлмөрийн физиологи, биеийн хүчний ажлын ачааллыг үнэлэх үзүүлэлтүүдийн норм тодорхойлох арга	MNS 5107 : 2001
9	ХАБЭА. Ачиж буулгах ажлын аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага	MNS 5076 : 2001
10	ХАБЭА. Өргөх зөөх ачааны массын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 4970 : 2000
11	Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө	MNS 4643 : 1998
12	Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэл. Ерөнхий шаардлага	MNS 4931 : 2000
13	Галын аюулгүй байдал. Нэр томьёо ба тодорхойлолт	MNS 0640 : 1989
14	Галын аюултай бүтээгдэхүүний ангилал, зэрэглэл	MNS 4999:2000
15	Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн стандартын систем. Галын аюулгүй байдал ерөнхий шаардлага	MNS 4244 : 1994
16	Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм	MNS 5566 : 2005
17	Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага	MNS 5390 : 2004
18	Шатамхай тосны тэсрэлт. Галын аюулгүй байдал. Ерөнхий техникийн шаардлага	MNS 0012-105:1994
19	ХАБЭА. Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага	MNS ISO 13688 :2000
20	Толгой хамгаалах хэрэгсэл, сонсгол хамгаалах хэрэгсэл, /чихэвч, бөглөө/	MNS 5388 : 2004
21	Толгой хамгаалах хэрэгсэл, нүд хамгаалах хэрэгсэл, нүдний шил	MNS 5389 : 2004
22	Толгой хамгаалах хэрэгсэл. Дуулга	MNS 5621 : 2006

№	Стандартын нэр	Тэмдэглэгээ
23	Толгой хамгаалах хэрэгсэл. Нүүрэвч /химийн хорт бодис, механик биет, дулаан гэрлээс хамгаалах нүүрэвч/	MNS 5624 : 2006
24	Амьсгалын замыг хамгаалах хэрэгсэл /хошуувч, шүүлтүүртэй баг, тусгаарласан агаартай бүтэн баг/	MNS 5620 : 2006
25	Гарын хамгаалалт бээлий. Ерөнхий шаардлага	MNS 5622 : 2011
26	Хөлийн хамгаалалт. Ажлын тусгай гутал	MNS 5623 : 2006
27	Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хамруулан MNS-OHSAS 18001 : 2012 тоот монгол улсын стандартчиллын үндэсний зөвлөлийн 2012 оны 11-р сарын 22 өдрийн 27 дугаар тогтоолоор баталсан байдаг. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын үнэлгээ /ХЭМАБ/ бүхий аж ахуй нэгж байгууллагуудтай холбоотой өөрсдийн эрсдэлийг хянаж, үйл ажиллагаагаа сайжруулах боломжийг бүрдүүлэх ХЭМАБ-ын удирдлагын тогтолцооны шаардлагыг тогтоосон байна.	MNS-OHSAS 18001 : 2012

БҮЛЭГ 3. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭЛТ

3.1. Төслийн байгаль орчны удирдлагын тогтолцоо

Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ: Эдэлбэр газруудыг зөв ашиглан байгаль орчныг унаган төрхөөр нь хадгалан хамгаалах ажлыг уурхай барьж байгуулах цагаас эхлэн хатуу хяналт тавьж ажиллах шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах зорилгоор дараах ажлуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Уурхай байгуулах үед байгаль орчныг хамгаалах хяналтын алба байгуулан ажиллах
- Шатахуун болон шатах тослох материалаар хөрс бохирдуулах, олон салаа зам гаргахаас сэргийлэхийн тулд тээврийн хэрэгслийн зогсоол, засварын бүс, уурхайн дотоод авто замын маршрутыг шинэчилж байнга засвар, үйлчилгээ, усалж арчилж байх
- Хуурай хог хаягдлын зориулалтын цэгийг байгуулах
- Уурхайн үйл ажиллагааны явцад гарсан хоёрдогч түүхий эдийн хог хаягдлыг тусгай цэгт цуглуулж төвлөрсөн цэгт тушаах
- Ахуйн бохир усны зориулалтын цэгийг ариутган цэвэрлэж байх
- Усны хэрэглээнд хяналт тавьж, хэрэглэсэн усны балансыг гаргаж байх
- Уурхайн ашиглалтын үед гал гарч болзошгүй хэсгүүдэд гал унтраах анхан шатны багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр тоноглож хангах
- Ил гал гаргах, тамхи татахыг хориглосон санамжуудыг нефтийн бүтээгдэхүүн болон тэсрэх материалын агуулах болон түүнтэй харьцдаг хэсгүүдэд байрлуулах
- Ажлын байр, зам талбайд ХАБЭА-н ба замын хөдөлгөөний дүрмийн тэмдэг, тэмдэглэгээ болон дохио санамжуудыг хийж тавих
- Галын онцгой аюултай ажлын байр, техник тоног төхөөрөмжүүдийг галын хороор байнга хангаж байх
- Гэнэтийн үерийн уснаас хамгаалах зориулалтаар тэсрэх материалын агуулах болон босоо гол ам орчмын болон ашиглаж буй талбайг тойруулан суваг татах далан байгуулах

- Байгаль орчинд нөлөөлөх хяналт шинжилгээний хөтөлбөр буюу мониторингийн хяналт шинжилгээний ажлын хүрээнд агаар, ус, хөрсний шинжилгээг мэргэжлийн байгууллагаар жилд 2-оос багагүй удаа байнга хийлгэж байх

БҮЛЭГ 4. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Урт гознорын ордтой хамгийн ойр суурин газар нь Төв аймгийн Эрдэнэ сум 23 км болон Улаанбаатар хотын Налайх дүүрэг 35 км. Төв аймгийн Эрдэнэ суманд нийт 1291 өрхөд 3762 хүн амьдардаг. Хүн амын нягтрал 1 хүн/км2 байдаг. Энэ нутагт халх үндэстэн зонхилох ба ихэнх хэсэг нь нүүдлийн мал аж ахуй эрхэлж, цөөн тооны хүмүүс газар тариалан эрхлэн амьдардаг. Дэд бүтцийн хувьд Улаанбаатар-Сайншандын хатуу хучилттай автозамаас 18 км, Улаанбаатар-Замын-Үүдийн төмөр замын 9-р зөрлөгөөс 20 км зайд, Налайх-Багануурын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 20 орчим км зайтай, Өвөр Жанчивлангийн 10 кВ-ын дэд станц хүртэл 5 км, орд нь дэд бүтцийн маш таатай нөхцөлд байрлаж байна. Зам харилцааны хувьд жилийн аль ч улиралд авто хөсөг саадгүй зорчих боломжтой.

2.1. Уур амьсгал өнөөгийн төлөв байдал

Монгол орны уур амьсгалын мужлалтаар Төв аймгийн нутаг дэвсгэр уур амьсгалын хувьд чийглэг хүйтэн, чийглэгдүү хүйтэвтэр, хуурайдуу хүйтэвтэр, хуурай дулаан гэсэн 4 мужид хуваагддаг бөгөөд төсөл хэрэгжиж буй газар нь хуурайдуу хүйтэвтэр мужид хамаарна. Энэ муж нь чийгийн хэмжээ дунд зэрэг, дулааны хүрэлцээ сайн, түрүүчийн мужийн адил эрт хүйтэрч орой дулаарах ба чийгшлийн хувьд бусад мужуудаас арай илүү. Нутаг дэвсгэр уур амьсгалын мужлалаар дулаавтар зунтай хагас чийглэг мужид хамаарна. Сумын нутаг дэвсгэр нь Хэнтий нурууны 2000-2700 м хүртэл өргөгдсөн, гол салбар уулсыг хамарч байгаа бөгөөд ерөнхийдөө чийг тунадас харьцангуй их, чийг дулааны коэфцент 2.2-оос дээш боловч дулаан дутагдалтай учир ургамалын өсөлт, хөгжилтэнд таатай биш, ургамал ургалтын хугацаа 90 хоногоос цөөн байдаг. Агаарын темпартур нь 79-84 хэм байна. Хоногийн хэлбэлзэл нь 20-25 хэмд хүрдэг ба энэ нь их газрын эрс тэс уур амьсгалын үндсэн шинж юм. Зун богино бөгөөд халуун биш хамгийн халуун нь 7-н сард дунджаар +15.6-37 хэм. Ойн хөвчдөө үүнээс ч бага, өвөл хүйтэн бөгөөд урт дундаж, темпартур нь -21-27 хэм, үнэмлэхүй хамгийн бага темпертур нь -41-46 хэм байна. Жилийн хүйтрэлгүй хугацаа 75-99 хоног +10 хэмээс дээшлэх дулааны нийлбэр нь 1233-1957хэм, тунадасны ихэнх нь буюу 70-90 хувь зуны улиралд орно. Баруун ба хойд зүгийн салхи зонхилдог ба томоохон голын хөндий ай савд уул хөндийн салхи тохиолдоно. Нутгийн гол мөрний хөлдөлт 10 дугаар сарын дундуур явагдаж 4 сарын сүүлээр гэсэх боловч ой хөвчийн өндөр сарьдаг уулсаас эх авсан гол горхины ихэнх нь зуны турш мөсөн бүрхүүлтэй байдаг. Хаврын оройн хүйтрэлт 6 дугаар сарын дундуур намар эртний хүйтрэл нь 8 сарын сүүлийн 10 хоног 9 дүгээр сарын эхээр тохиолдоно. Цасан бүрхүүл харилцан адилгүй тогтох бөгөөд дундаж зузаан 15-20 см, намрын анхны цас 9 сарын эхээр орно. Цастай байх хугацаа дундажаар 120-150 хоног үргэлжилнэ.

2.2. Физик-газарзүй

Төв аймгийн Эрдэнэ сум нь тал хээрийн бүсэд хамаарагддаг. /Засгийн газрын 2006 оны 71-р тогтоол/ Эрдэнэ сум нь Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужид Хэнтийн захын хэсгийн тойрогт багтана. Геоморфологийн хувьд Хэнтийн уулын тогтолцооны салбар уулын өмнөд хэсэг болох жижиг толгодорхог гадаргуутай бүсэд багтдаг. Орчин үеийн рельефийн бүрдэлтэд дотоод болон гадаад хүчин зүйлийн процесс ихээхэн үүрэг гүйцэтгэж, орчин үеийн рүльефийн дүр төрхийг бүрдүүлсэн. Идэгдэл-элэгдэл маягийн рельефт голын зарим нэг хажууг оруулах ба энэ нь идэгдлийн гадаргатай шинжээ алдсан байх нь ажиглагддаг. Хөндийн I ба II дэнж бүрэлдсэн дээд плейстоцены настай, өндөр нам татмууд бөгөөд эдгээрийн өргөн нь 50-1000 м. Гольдрол нь гол төлөв 0.2-1.0 м гүн, 0.510 м өргөнтэй байна. Угаагдлын үр дүнд үүссэн хуримтлалын гадаргуу нь хажуугийн буюу делювийн бөөгнөрлөөс тогтоно. Ордын талбай нь далайн түвшнээс дээш 1680-1780 м өргөгдсөн, Монгол Улсын нутаг дэвсгэрийн төв хэсгийн сэрүүн бүсэд багтдаг бөгөөд Хэнтийн нурууны баруун өмнөд төгсгөл, Нагалхаан уулын өмнөд салбар уулсын дүүрэгт оршдог. Талбай орчмын рельеф намхан уулархаг, гүвээрхэг, тал хээр зонхилсон бүтэцтэй. Газар хөдлөлтийн эрчим 5-6 балл. Сумын нутаг дэвсгэрийн 80 гаруй хувь нь малын бэлчээр, хадлан тариалан, үлдсэн хувийг ой тайга эзэлдэг..

2.3. Газрын гадарга, хэвлий өнөөгийн төлөв байдал

Төслийн байршил орших нутаг буюу Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэр нь Монгол орны геоморфологийн мужлалаар Орон Сэлэнгийн бэсрэг уулсын мужид харъяалагдаж байгаа бөгөөд геоморфологийн хэв шинжийн ангиллаар Нам уулархаг, нуруу болон ухаа гүвээт, нугачаач тал гэсэн 2 хэв шинжийг харуулсан мужлалд багтах бөгөөд төсөл хэрэгжих талбайн байршил нь тэгш талархаг газар байх бөгөөд гадаргын дундаж налуу нь 0-10 хэм буюу тэгш тал газар байна. Тухайн газар нь хээрийн ургамал болох таана, цөөн тооны хүмүүл, хялгана, зарим нэр төрлийн шарилж, төлийн талбайн урд хэсгээр дэрс, агь болон цахилдаг түлхүү ургасан байгаа нь тус талбайд хийсэн байгаль орчны төлөв байдлын хээрийн судалгааны шатанд ажиглагдсан мөн тухайн талбайд ямарваа нэгэн цэвдгийн гаралтай шинж тэмдэг тодийлөн ажиглагдаагүй бөгөөд энэхүү орчин нь алаг цоог цэвдгийн тархалттай бүс нутагт харъяалагдаж байна.

2.4. Төслийн талбайн гадаргын усны төлөв байдал

Монгол орны усны сав газрын хувьд Эрдэнэ сумын нутаг дэвсгэр нь Хэрлэн голын сав газарт хамаарагдаж байна. Гэвч тухайн бүс нутагт буюу төслийн байршил орчимд ямар нэгэн гадаргын усны сүлжээ илрээгүй ба тухайн төслийн байршлын орчимд түр зуурын буюу хүчтэй аадар бороо орсны дараагаар түр зуурын ус тогтох магадлалтай байсан судалгааны явцад харагдаж байсан. Зэргэлдээх талбайнуудад хийгдсэн судалгаанаас үзэхэд энэ насны хурдасны доод хэсэгт элсэрхэг шаварлаг хурдас тогтоогдсон байна. Энэ шаварлаг хурдасны дээд үе болон дунд нь илрэх хэмхдэслэг үеүүд ус агуулдаг онцлогтой байна. Усны төвшин дунджаар 6.0-7.0м-ийн гүнд, хөндийн адагт 9.0м хүрдэг байна. Уст үеийн зузаан 5.0м хүрэх тул үйлдвэрлэлийн зориулалттай усны хэрэгцээг хангахад энэ насны уст давхарга голлох үүрэгтэй.

Талбайн хэмжээнд болон түүний ойр орчимд байнгын урсгалтай гол, тогтмол устай нуур байхгүй, талбайн дундуур хойноос урагш чиглэсэн Улаан худгийн ам нэртэй V хэлбэрийн хөндийд хур тунадас элбэг жилийн зуны улиралд түр зуурын урсгалтай жижиг булаг урсдаг. Усан сүлжээ муу хөгжсөн, жилийн дөрвөн улиралд хур тундасны усаар болон худаг, булаг шандны усаар тэжээгддэг.

Жилийн хур тунадасны хэмжээ 196-288 мм ба ихэвчлэн (нийт тунадасны 51-62 %) зуны улиралд буюу 7, 8-р сард буудаг. Хүн малын унданд зөвхөн худгийн усыг хэрэглэх ба худгуудыг хуурай сайр, хөндий орчимд гаргасан байдаг. Худгийн усны гүний түвшин 2-7 м байдаг.

2.5. Хөрсөн бүрхэвч өнөөгийн төлөв байдал:

Төсөл хэрэгжихээр төлөвлөгдсөн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг нь газрын гадаргуугийн хувьд ухаа жалга, тал бүхий уул толгод, өндөрлөг сэрвэн хад чулуу элбэгтэй уулархаг гадаргуу болон түүний хоорондох хотгор газраас бүрдэх бөгөөд өндөр нь 1500-1700 м орчимд хэлбэлзэнэ. Энэ газар нь хөрс-газарзүйн мужлалтаар хар хүрэн хөрстэй Халхын дундад талын тойрогт багтана. Ургамал бүрхэвчид агь-хазаар өвс-хялганат, хялгана-хазаар өвст хээр эрс давамгайлахын сацуу үетэн-агь-харганат хээр, мөн өндөрлөг уул толгодын бэлээр бушилзат хээр зонхилно. Судалгааны талбайн хэмжээнд тархсан хөрсөн бүрхэвчид уулын ердийн харшироон болон ердийн хархүрэн хөрс зонхилох суурийг эзэлнэ.

Судалгааны талбайн уулт атриат өргөгдлийн элэгдэл-тектоникийн гаралтай гадаргатай байна. Газрын гадарга дээр хотгор гүдгэрийг өөрчлөгч орчин үеийн үйл явцын эрчим сул, усны нэл угаагдал зонхилно. Антропогений нөлөөнд харьцангуй бага өртсөн, харин ердийн хөрсөн замын улмаас хөрсний дээд өнгөн үе давхарга элэгдэл, эвдрэлд өртсөн байдалтай байна. Мөн тухайн төслийн байршил нь 2 овооны голоор байрлах ба тухайн 2 овооны голоор жалга ихтэй ба хөрсний эвдрэлд нэлээдгүй их орсон байдалтай байх ба 0.7 га газар жалгатай хөрс жалгаар урсах борооны уснаас болж хүчтэй эвдэрсэн байдалтай байна. Тухайн судалгааны явцад хөрсний 2 дээж авч Газарзүй, Гео-Экологийн хүрээлэнгийн хөрс судлалын газраар шинжилгээ хийлгэсэн ба тухайн хөрсний судалгааны 2 дээжийг шинжилгээнд өгсөн.

Төслийн талбайн агрохимийн дүн шинжилгээнээс авч үзэхэд тухайн төслийн талбайн хөрсөн бүрхэвчтэй гадаргын агрохимийн үзүүлэлтүүд нь тухайн хөрс нь pH-ийн агууламж урвалын орчин саармагжсан байх бөгөөл давсны агууламж бага ялзмагын агууламж нь 5,22%-6.46% буюу ялзмагын агууламжаар баялаг, шим тэжээлийн элментийн агууламж сайтай байна. Төслийн талбайн хөрсөн бүрхэвчийн хэв шинж нь шаварлаг бүтэцийн найрлага багавтар, 1-0.05 хэмжээт хурдас чулуулаг элбэг тархсан элсэрхэг бүтэцтэй байх ба уг механик бүрэлдхүүн элсэрхэг механик бүрэлдэхүүнтэй.

Төслийн үйл ажиллагаа явуулж буй талбайн байршилд хийсэн хөрсөнд агуулагдах хүнд металлийн бохирдуулагч бодсын агууламжийг олж тогтоох цаашид үйл ажиллагаа явуулах явцад уг задлан шинжилгээний тоо баримтын өөрчлөлтийг харж мониторнг хийх зорилгоор хөрсний дээж авч хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид өгч шинжлүүлэхэд Кадми болон Зэс илрээгүй, Хүлцэх агууламж MNS 5850:2016 стандартаас давсан үзүүлэлт байхгүй байна.

2.6. Ургамлан бүрхэвч өнөөгийн төлөв байдал

Тус бүс нутагт буюу Төв аймгийн Эрдэнэ сумын нутгийн баруун хэсэг нь хээрийн бүсэд хамаарагдах ба тухайн бүс нутгийн ургамлын хэв шинж нь говь-хээрийн бүсэд түлхүү ургадаг ургамал зонхилох хандлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евразийн хээрийн мужид хамаарна. Энэ тойрогт шивээт хялгана-хазаарганат (Stipabaicalensis-Cliestogenessquirrosa), шивээт хялганат-агьт (Stipabaicalensis-Artimisiafrigida), шивээтхялганат-өлөнт (Stipabaicalensis-Carixdiriuscula), харганат - (Caragana), харгана-агьт (Caragana–Artemisiafrigida) үетэнт зонхилох ба нийт 509 дээд ургамал байдгаас 403 өвслөг, 63 зүйл нь модлог, сөөглөг юм. Судалгааны

объектын орчим жижиг бутлаг үетэн-хялганат бүлгэмдэлд Stipa krylovii, Cliestogenes squarrossa, Koelera cristata, Sibbaldianthe adpressa, Haplophyllum dauricum, Astragalus galactites зонхилж байсан болно.

Энэ бүс нутаг нь талын ландшафтын өндөрлөг талын (1115-1128 м хүртэл) бага хэрчигдэлтэй, элэгдлийн умард хуурай хэсгийн ландшафттай. Байгалийн мужлалын хувьд давхаргат өндөрлөг тал, үлдмэл цулдмал уул бүхий хуурай хээрийн дэд мужийн 10 %-аас бага мараа-марз бүхий Умард хуурай хээрийн районд хамаарна.

2.7. Төслийн талбай орчмын амьтны аймаг

Монгол орны төв хэсгийн хээрийн ургамалшилтай нутагт олон салаа гүн нүх малтан орогнож голдуу ногоон өвсөөр хооллогч мэрэгчид зонхилно. Хуурай хээрийн бүсэнд мэрэгчид дундаас үлийн цагаан оготно хамгийн дэлгэр тархана. Ялангуяа Монголын Дорнод талд өргөн тархаж Хангайд зөвхөн гол нурууны өвөр хажуугаар оршин Хан хөхийн нуруунаас баруун тийш үл үзэгдэнэ. Үлийн цагаан хулганы удаах байранд дагуурын үхэр огодой орох боловч түүнтэй адил тийм асар их тоонд хүрэхгүй. Хээрийн бүсийн зүүн ба зүүн хойт этгээд дэх арай чийглэг хиаг-хялганат хээрт дагуурын зурам элбэн дайралдана. Хээрийн бүсийн элсэрхэг газраар шар сүүлт, чичүүл тархдан бөгөөд заримдаа сүрхий шигүү оршино. Чичүүл нь говийн бүсэнд илүү нийтлэг тул хээрийн бүсэнд зөвхөн элстэй нутгаар л дайралдана. Бусад мэрэгчдээс Сибирийн алаг даага, хөх ишнүүхэй, орог зусаг, тарвага, туулай гэх мэрэгчдийг нэрлэж болох бөгөөд сибирийн алаг даага нь өндөр уул, цөлийн бүс 2-оос бусад газарт өргөн тархдаг бөгөөд Монголын дорнод талд нарсан өвст, агь-хялганат, хялганат хээрт, Хангай, Монгол Алтайн уулст ботуульт-хээрт голчлон дайралдана.

БҮЛЭГ 5. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Ил уурхайн олборлолтын явцад газрын байгалийн рельеф эвдрэх бөгөөд уурхайн ухаш, хөрсний овоолго, технологийн талбай, түр замууд үүсэх замаар газрын гадаргын анхдагч төрх өөрчлөгдөнө. Уурхайн ашиглалтын хугацаанд үүсэх энэхүү өөрчлөлт нь олборлолтын талбайд шууд нөлөөлөх бөгөөд орон зайн хувьд хэсэгчилсэн боловч урт хугацааны шинжтэй байна.

Геоморфологийн тогтвортой байдал алдагдах

Хөрс хуулалт болон уулын ажлын улмаас гадаргын хамгаалах үе устаж, усны урсац төвлөрөх нөхцөл нэмэгдсэнээр жалга суваг үүсэх, гадаргын элэгдэл эрчимжих эрсдэл бий болно. Ялангуяа чулуурхаг налуу гадаргатай хэсгүүдэд хур борооны дараах механик элэгдэл нэмэгдэх магадлалтай.

Газрын хэвлийн нөөц шавхагдах

Төслийн үндсэн үйл ажиллагаа нь ашигт малтмал олборлох тул газрын хэвлийн ашигт нөөц буурах нь зайлшгүй, эргэлт буцалтгүй нөлөөлөлд тооцогдоно. Гэвч энэхүү нөлөөлөл нь ашигт малтмал ашиглах зөвшөөрлийн хүрээнд хийгдэж байгаа бөгөөд төслийн үндсэн зорилгоор тодорхойлогдоно.

Ил задгай эвдэрсэн талбай нэмэгдэх

Олборлолтын үед нөхөн сэргээлт хийгдээгүй талбайд салхи, усны элэгдэл идэвхжих, хөрсний тогтворжилт алдагдах эрсдэл үүснэ. Эвдэрсэн газрын хэмжээ уурхайн ахилтаас шалтгаалан нэмэгдэх боловч шат дараалсан техникийн болон биологийн нөхөн сэргээлтээр бууруулах боломжтой.

Хүснэгт 7. . Болзошгүй нөлөөллийн үнэлгээний Леопольдын матриц

Төслийн үе шат / Байгаль орчны хүчин зүйл	Хайгуул	Олборлолт	Боловсруулалт	Тээвэрлэлт	Хаалтын үе	Бүгд
Хөрсний эвдрэл	-4/6	-8/9	-5/7	-2/4	+3/6	-19, +3/32
Гүний болон гадаргын ус	-2/4	-3/10	-4/10	-1/2	+2/4	-10, +2/30
Агаарын чанар	-1/3	-6/9	-7/9	-5/8	+2/4	-19, +2/34
Ургамалын төрөл зүйл	-3/5	-7/9	-2/4	-3/5	+2/5	-15, +2/28
Амьтны амьдрах орчин	-2/4	-4/10	-3/5	-4/6	+1/2	-13, +1/27
Орон нутгийн хүн ам	+1/3	+3/6	+2/5	-2/3	+4/6	+10, -2/23
Дэд бүтэц зам тээвэр	0/0	+2/4	+2/4	-3/5	+1/3	-3, +5/16
Эдийн засгийн боломж	+2/4	+5/8	+4/6	+3/5	0/0	+14/23
БҮГД	+3,-12/29	+10,-28/65	+8,-21/50	+3,-20/44	15/30	

Дээрх хүснэгтийн босоо баганууудын нийлбэр дүн буюу Байгаль орчны хүчин зүйлд нөлөөлөх нөлөөллийг нөлөөллийн зэрэглэлийн түвшний шалгууруар авч үзвэл сөрөг нөлөөлөл нь хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл нь -19,+3 байгаа нь их нөлөөлөлтэй, гүний болон гадаргын усанд үзүүлэх нөлөөлөл -10,+2 байгаа нь дунд нөлөөлөлтэй, агаарын чанарт үзүүлэх нөлөөлөл -19,+1 байгаа нь их нөлөөлөлтэй, ургамлын төрөл зүйлд үзүүлэх нөлөөлөл -15,+2 байгаа нь их нөлөөлөлтэй, амьтдын амьдрах орчинд нөлөөлөл -13, +1 байгаа нь дунд нөлөөлөлтэй байгаа бол эерэг нөлөөлөл нь орон нутгийн хүн ам нэмэгдэх, дэд бүтэц сайжрах, эдийн засгийн боломж нэмэгдэх зэрэг болон уурхайн хаалтын үеийн нөхөн сэргээлтээс хамааран байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байна. Мөн төслийн үе шатаар нь авч үзвэл олборлолтын үе шатны үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл их байна.

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Уурхайн тээврийн зам. Уурхайн гол агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэг нь уурхайн тээврийн замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр замаас үүсэх тоосжилт юм. Уурхайн тээвэрлэлт нь овоолго тээврийн хүнд даацын тээвэр болон үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөс бүрдэнэ. Тээврийн замаас үүсэх тоос,тоосонцрын ялгарлын хэмжээг АНУ-ын Байгаль орчныг Хамгаалах Агентлаг AP-42 section 13.2.2 Unpaved Road эх үүсвэрийн гарын авлагын аргазүйг ашиглан тооцоолов. Тээврийн зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь тоосжилтын хамгийн гол эх үүсвэр бөгөөд уурхайн үйлажиллагаанаас үүсэж байгаа нийт тоос,тоосонцрын 80%-с илүүг үүсгэдэг.Үйлдвэр дотоод тээвэрлэлт нь овоолго болон хүдрийн бункер хооронд хийгдэх хүнд даацын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн юм.

Ухаш олборлолт. Уурхайн үндсэн үйл ажиллагаа буюу олборлолт уурхайн ухаш дотор явагддаг.Уулын цулыг утгуурт ачигч буюу экскаватороор тээврийн хэрэгсэлд ачихад хялбар болгохын тулд уурхайн хүдэр болон хөрсний биетэд өрөмдөж тэсрэх бодисоор тэсэлгээ хийнэ.Тэсэлгээгээр суларсан хөрс,хүдрийг тээврийн хэрэгсэлд утгуурт ачигчаар ачна. Өрөмдлөг,тэсэлгээ,ухаж ачих,тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр агаарт тоосжилт үүснэ.

Овоолго үүсэх. Ухаш олборлолтоор тээврийн хэрэгсэл уулын цулыг уурхайн овоолго дээр тээвэрлэж буулгана.Тээврийн хэрэгслээс овоолгод материал буулгахад болон овоолго үүсгэх автомеханизм болох бульдозерын үйл ажиллагаагаар орчны агаарт тоос,тоосонцор ялгарна.

Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас үүсэх агаар бохирдуулагч. Тээврийн хэрэгслийн түлшний шаталтаас олон төрлийн агаар бохирдуулагч ялгардаг.Түлшний найрлагад агуулагдах бодисууд болох хүхэр болон нүүрстөрөгч,дэгдэмхий органик нэгдлүүдээс шаталтаар агаарт хүхрийн ислүүд,нүүрстөрөгчийн дан болон давхар ислүүд, метан болон метан агуулаагүй ууршимтгай органик,нэгдлүүд болон азотын ислүүд ялгардаг.

Уурхайн тээврийн замаас үүсэх тоосжилт. Сайжруулаагүй зам эсвэл замгүй хэсгээр тээврийн хэрэгсэл зорчих үед дугуйн даралтын хүчний үйлчлэлээр гадаргуун материал хэмхэрч нунтгардаг. Тээврийн хэрэгсэл зорчин өнгөрөх үед түүний ард дагалдан үүсдэг агаарын хүчтэй турбулент хөдөлгөөний үйлчлэлээр замын гадаргуун материалын эгэл хэсгүүд хөдөлгөөнд орох эргэлдэж буй дугуйгаар зарим хөрсний эгэл хэсгүүд дээш өргөгдөх болон зарим эгэл хэсгүүд доош унах зэргээр тоосжилт үүсдэг. Замын тухайлсан хэсгээс үүсэх тоосжилтын хэмжээ нь замын ачааллаас шугаман. замын гадаргын материалын шаварлаг(75 микроноос бага диаметртэй хөрсний бүрэлдэхүүн хэсэг)-ийн агууламжаас шууд хамааралтайгаар өөрчлөгддөг.

Уурхайн агаар бохирдуулагч бодисын ялгарлын тооцоолол/emission inventory/

Эх үүсвэрээс ялгарах ялгаралын факторыг тооцоход АНУБХА-АР42 (USEPA - AP42).Австрали улсын (NPA Emission estimation technique manual for mining ver3.1) нүүрсний ил уурхайгаас үүсэх тоосонцрын хаягдлын факторуудын тооцох аргазүй болон төслийн ТЭЗҮ-гын мэдээллийг тооцоонд ашиглав.

Уурхайн ухашаас материал олборлох болон түүхий эдийн овоолго материал буулгахад үүсэх тоосжилт. Материалыг асгах процессоос үүдэлтэй үүсэх тоосны ялгарлын фактор тодорхой хэмжээний материалыг шилжүүлэхэд үүсэх тоосны хэмжээгээр илэрхийлэгдэх ба дараах эмпирек томьёог ашиглан тооцоолдог.Уурхайн ухашаас тээврийн хэрэгсэлд хөрс,түүхий эд ачих болон хөрс,түүхий эдийн овоолго болон үйлдвэрийн тэжээлийн бункерт хөрс,түүхий эд буулгахад үүсэх тоос,тоосонцрыг доорх томьёогоор тоосны эх үүсвэрийн хаягдлыг тооцоолох бөгөөд материалын шинж чанар болон ашиглах төхөөрөмжийн техникийн үзүүлэлтээс хамаарсан доорх тэгшитгэлээр тооцоолно.

3.1.Төслийн үйл ажиллагаанаас усан орчинд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ус зүйн хувьд Төв Азийн гадагш урсгалгүй ай савын бүсэд багтах бөгөөд талбайн хэмжээнд болон түүний ойр орчимд байнгын урсгалтай гол, тогтмол устай нуур байхгүй, талбайн дундуур хойноос урагш чиглэсэн Улаан худгийн ам нэртэй V хэлбэрийн хөндийд хур тунадас элбэг жилийн зуны улиралд түр зуурын урсгалтай жижиг булаг урсдаг. Усан сүлжээ муу хөгжсөн, жилийн дөрвөн улиралд хур тундасны усаар болон худаг, булаг шандны усаар тэжээгддэг. Жилийн хур тунадасны хэмжээ 196-288 мм ба ихэвчлэн (нийт тунадасны 51-62 %) зуны улиралд буюу 7, 8-р сард буудаг. Хүн малын унданд зөвхөн худгийн усыг хэрэглэх ба худгуудыг хуурай сайр, хөндий орчимд гаргасан байдаг. Худгийн усны гүний түвшин 2-7 м байдаг.

Судалгааны талбайн морфологи нь тухайн хэсгийн тектоникийн идэвхжилтэй салшгүй холбоотой бөгөөд талбай нь Төв Монголын суперблокийн Улаанбаатарын террейнд багтана. Ерөнхийдөө хотгор структур нь уртрагийн дагуу чиглэлтэй жижиг хагарлуудаар хянагдана. Бага хэрчигдэлтэй намхан уулс, толгод, гүвээрхэг гадаргуу бүхий тачир ургамлын бүрхэвчтэй, ой мод, гол горхигүй, хуурай эх газрын эрс тэс уур амьсгалтай бүсэд оршдог. Уул толгод нь тэгшивтэр бөмбөгөр оройтой, налуу хажуутай, гуу жалгандаа үерийн усаар идэгдсэн, хуурай сайруудтай, толгод хоорондын битүү хотгоруудад хур бороотой үед түр зуурын жижиг нуур цөөрөм үүсдэг.

Хүснэгт 8. Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Нөлөөллийн хэлбэр		Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
			Н	А1	А2	А3	В1	В2	С	Σ	
1	Гадаргын усны нөөц баялаг	Хог хаягдал									Бага
2	Газрын доорх усны нөөц баялаг	Уурхайн үйл ажиллагаа									Дунд
3		Ажилчдын унд ахуй									Дунд
4	Усны чанарын өөрчлөлт	Уурхайн үйл ажиллагаа									Дунд
Дүгнэлт			Дунд								

3.2.Төслийн үйл ажиллагаанаас газрын гадарга хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжихээр төлөвлөгдсөн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг нь газрын гадаргуугийн хувьд ухаа жалга, тал бүхий уул толгод, өндөрлөг сэрвэн хад чулуу элбэгтэй уулархаг гадаргуу болон түүний хоорондох хотгор газраас бүрдэх бөгөөд өндөр нь 1500-1700 м орчимд хэлбэлзэнэ. Энэ газар нь хөрс-газарзүйн мужлалтаар хар хүрэн хөрстэй Халхын дундад талын тойрогт багтана. Ургамал бүрхэвчид агь-хазаар өвс-хялганат, хялгана-хазаар өвст хээр эрс давамгайлахын сацуу үетэн-агь-харганат хээр, мөн өндөрлөг уул толгодын бэлээр бушилзат хээр зонхилно. Судалгааны талбайн хэмжээнд тархсан хөрсөн бүрхэвчид уулын ердийн харшироон болон ердийн хар хүрэн хөрс зонхилох суурийг эзэлнэ.

ХХүснэгт 9. Хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Нөлөөллийн хэлбэр	Бохирдлын эхүүсвэр	Нөлөөллийн үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
			Н	А1	А2	А3	В1	В2	С	∑	
1	Боломжит нөлөөлөл	Бүтээн байгуулалтын явцад хөрс эвдрэлд өртөх, зулгарах, устах	-1	1	2	2	1	2	2	-10	Дунд
		Тээвэрлэлтийннөлөөгөөр шороон зам үүсэх	-1	1	2	3	1	2	1	-10	Дунд
		Ажилчидын байршихтай холбоотой хог хаягдал, орчны талхагдал үүсэх	-1	1	1	2	1	2	1	-8	Бага
2	Сөрөг нөлөөлөл	Бүтээн байгуулалтын ажлын явцад талбай бэлтгэхзорилгоор хөрс	-1	1	3	3	1	2	2	-12	Дунд

		хуулах, шимт хөрс хадгалах									
		Төслийн бүтээн байгуулалт болон цаашдын үйл ажиллагааныявцад хөрс талхагдалд өртөх	-1	1	2	2	1	2	2	-10	Дунд
3	Хуримтлагдах нөлөөлөл	Төслийн үйл ажиллагаа эхлэх үед ажилчдын хөл хөдөлгөөнөөр хөрс орчны доройтол үүсэх	-1	1	1	2	1	2	1	-8	Бага
		Төслийн өдөр тутмын үйл ажиллагаанаас үүдэлтэй хог хаягдлаар хөрс бохирдох	-1	1	1	2	1	2	1	-8	Бага
Дүгнэлт			Дунд								

Төв аймгийн Эрдэнэ сумын нутгийн баруун хэсэг нь хээрийн бүсэд хамаарагдах ба тухайн бүс нутгийн ургамлын хэв шинж нь говь-хээрийн бүсэд түлхүү ургадаг ургамал зонхилох хандлагатай байгаа нь судалгааны явцад ажиглагдсан. Энэ газар нутаг нь ургамал газарзүйн мужлалын хувьд Евразийн хээрийн мужид хамаарна. Энэ тойрогт шивээт хялгана-хазаарганат (Stipabaicalensis-Cliestogenessquirrosa), шивээт хялганат-агът (Stipabaicalensis-Artimisiafrigida), шивээтхялганат-өлөнт (Stipabaicalensis-Carixdiriuscula), харганат - (Caragana), харгана-агът (Caragana–Artemisiafrigida) үетэнт зонхилох ба нийт 509 дээд ургамал байдгаас 403 өвслөг, 63 зүйл нь модлог, сөөглөг юм. Судалгааны объектын орчим жижиг бутлаг үетэн-хялганат бүлгэмдэлд Stipa krylovii, Cliestogenes squarrossa, Koelera cristata, Sibbaldianthe adpressa, Haplophyllum dauricum, Astragalus galactites зонхилж байсан болно.

Цаг уурын эрс тэс уур амьсгалаас шалтгаалан тал хээрийн ургамал тархсан байдаг. Бага хэмжээний горхи булагтай, орчны өвс ургамлын бүрхэвч үндсэндээ өвслөг ургамал (хялгана, дэрс, цахилдаг, бут сөөг, шивээ) зонхилдог.

Хүснэгт 10. Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
			Н	A_1	A_2	A_3	B_1	B_2	С	∑	
1	Байгалийн ургамалжил устах	Уул уурхайн бүтээн байгуулалт түүнийг дагалдан бий болох бусад жижиг барилга байгууламжуудыг байгуулах, ашиглах зэргээс	-1	1	2	2	1	1	2	-9	Дунд

2	Ургамлын ургах чадварыг алдагдуулах	Машин техникийн хөдөлгөөн, хог хаягдал ба шороо, тоосжилт нь ургамлан бүрхэвч дээр бууж хуримтлагдах	-1	1	2	2	1	1	2	-9	Дунд
3	Урт үндэстэй, олон наст ургамалд нөлөөлөх	Бага гүний усны татралтнь гүний усаар тэжээгддэг ургамлын ургалт саарах, мөхөх улмаар ургамал нөмрөгийн доройтолд өртөх	-1	1	3	2	1	1	1	-9	Дунд
4	Гадаргын устай холбоотой ургамалжил мөхөх	Хүчтэй аадар борооны гадаргын урсац, нэл угаагдлаар ургамлан нөмрөг бохирдох, ургамлан бүрхэц багасах, зүйлийн бүрэлдэхүүний тоо цөөрөх, улмаар ургамлан нөмрөг устаж болзошгүй	-1	1	1	1	1	1	1	-6	Бага
Дүгнэлт			Дунд								

Ордын талбай болон зам дагуух нөлөөллийн бүсэд ургамал бүлгэмдэл хэвийн ба бага зэрэг доройтсон төлөв байдалтай байна. Харин талбайд тохиолдох ховор болон бэлчээр, тэжээлийн үнэт ургамлууд шууд нөлөөлөлд өртөхгүй боловч нөлөөллийг бууруулах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд тодорхой хугацааны нөхөн сэргээлтийн ажил шаардлагатай. Тиймээс нийт эзэмшлийн талбайн хэмжээ, зам түүнтэй адилтгах хэмжээтэй өөр газарт таримал ургамал тарьж нөхөн сэргээлтийн ажлыг хийлгэх хэрэгтэй. Энэхүү нөхөн сэргээлтийн ажлаа сум орон нутагт зайлшгүй хэрэгтэй бэлчээрийн газарт нутгийн бэлчээр, тэжээлийн үнэт ургамал болон ховор, эмийн ашигт, цайны ургамлыг нутгийн ард иргэдийн оролцоотойгоор тарималжуулах шаардлагатай.

Дээрх нөлөөллийн хүснэгтээс харахад Уул уурхайн бүтээн байгуулалт түүнийг дагалдан бий болох бусад жижиг барилга байгууламжуудыг байгуулах, ашиглах зэргээс ургамлан нөмрөг нөлөөлөх нөлөөлөл дунд зэрэг байна.

3.3. Төслийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Ордын уурхайн үйл ажиллагааны явцад агаар мандалд хаях бохирдуулагч эх үүсвэрүүдэд цэг нь болон талбайн, түр зуурын эх үүсвэрүүд багтана. Агаарт бохирдуулагч эх үүсвэрүүдийг дараах байдлаар хуваан үзэж болно. Үүнд:

- Дулааны системийн цэгэн эх үүсвэр;
- Материал дамжуулах, тээвэрлэх хэсгүүд дэх бохирдлын цэгэн эх үүсвэрүүд;

- Түүхий эд дамжуулах системийн цэгэн эх үүсвэрүүд;
- Тээврийн хэрэгслээс ялгарах бохирдуулагчид;
- Ил талбай, зам, овоолгууд зэрэг болно.

Агаарын бохирдлын эх үүсвэр:

Тоосжилт: Уурхайн үйл ажиллагааны явцад газар шорооны ажил, тэсэлгээ хийх, малтах, өрөмдөх, овоолго хийх үед уулын чулуулгаас их хэмжээний тоос гардаг.

Тоосны 0.1-10.0 хүртэл микрометрийн хэмжээ нь хүний уушгинд муугаар нөлөөлнө. Уурхайд ажиллагсад нь цахиурын исэл агуулсан их хэмжээний тоостой нөхцөлд ажилласнаас силикоз, антрокоз буюу уушги тоосжих аюултай өвчнөөр өвчилдөг. Их хэмжээний тоостой нөхцөлд ажиллах нь эрүүл мэндэд аюултай. Ийм нөхцөлд удаан хугацаагаар ажиллавал уушги пнемкониоз буюу силикозоор өвчилнө. Мөн тоос нь янз бүрийн хортой металл их хэмжээгээр агуулсан бол хордлого болно.

Хорт хий: Уурхайд нүүрстөрөгчийн давхар исэл, хүхэрлэг хий, азотын давхар исэл зэрэг тодорхой хэмжээний химийн бодис агуулагдаж байдаг. Энэ нь уурхайн машин механизмын хөдөлгүүрийн дизель түлш, тэсэлгээнээс үүсэх гал зэргийн дутуу шаталтаас нүүрстөрөгчийн давхар исэл, нүүрстөрөгчийн дутуу исэл үүсдэг. Машин механизмын бензин, дизелийн дутуу шаталтаас мөн тэсрэлт дэлбэрэлтийн улмаас үүссэн галаас азотын исэл ялгардаг. Нүүрстөрөгчийн дутуу исэл хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлөх бөгөөд учир нь хүний цусан дахь хүчилтөрөгчийг зөөх үйл ажиллагааг саатуулдаг байна.

Дизель хөдөлгүүрт машин механизм, тээврийн хэрэгслүүдээс уурхайн ойр орчны агаарт бохирдуулагчид ялгаруулна.

Төслийн үйл явцад хэрэглэгдэх дизель хөдөлгүүрт машин механизм, тээврийн хэрэгслүүдээс уурхайн ойр орчны агаарт бохирдуулагч бодис ялгаруулна.

Хүснэгт 11. Агаарт үзүүлэх нөлөөллийн эрчим

№	Нөлөөллийн хэлбэр	Бохирдлын эх үүсвэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
			Н	А1	А2	А3	В1	В2	С	∑	
1	Тоосжилт	Машин техникийнашиглалт	-1	1	2	2	1	1	1	-8	Бага
		Тэсэлгээ	-1	1	2	3	1	1	1	-9	Дунд
		Хөрс хуулалт	-1	1	2	3	1	1	2	-9	Дунд
2	Ууршилт	Газрын тосны бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлтийн үеийн ууршилт алдагдал	-1	2	2	2	1	2	1	-10	Дунд

3	Дуу шуугиан /физик бохирдол/	Машин техник	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
		Тэсэлгээ	-1	1	2	3	1	1	1	-9	Дунд
4	Үнэр /физик бохирдол/	Хог хаягдалыг цаг тухайд нь зайлуулаагүй, ариутгаагүйгээс	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
Дүгнэлт			Дунд								

Төслийн үйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл Төсөл хэрэгжих Төв аймгийн Эрдэнэ сумийн нутаг нь Монгол орны төв хэсгийн хээр талын амьтны аймгаар баялаг хэсэгт хамаарна. Цаг уурын эрс тэс уур амьсгалаас шалтгаалан тал хээрийн амьтан тархсан байдаг. Бага хэмжээний горхи булагтай. Амьтны төрлөөс цагаан зээр, чоно, үнэг, тарвага, зурам гэх мэт амьтад, шувуудаас бүргэд, сар, шонхор, болжмор зэрэг шувууд тааралдана.

Хүснэгт 12. Амьтны аймагт нөлөөлөх байдлын

№	**Болзошгүй нөлөөлөл**	**Нөлөөллийн хэлбэр**	**Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт**								**Нөлөөллийн түвшин**
			Н	А1	А2	А3	В1	В2	С	∑	
1	Амьтад үхэж хорогдох	Өнгөн хөрсийг хуулснаар мэрэгчид, мөлхөгчид болон сээр нуруутан амьтдын амьдрах орчныг сүйтгэх	-1	1	1	2	2	1	2	-9	Дунд
2	Зарим зүйлийн шавж, сээр нуруугүйтэн амьтдын тоо буурах	Өнгөн хөрсийг хуулснаар үүдсэн экологийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс зарим зүйлийн шавжийн тоотолгой буурах, өсөн нэмэгдэж болзошгүй.	-1	1	1	2	2	1	2	-9	Дунд
3	Зэрлэгамьтад ойр орчмоос дайжих	Дуу чимээ, гэрэлтүүлэг, тээврийн хэрэглэлийн хөдөлгөөн ба машин техникийн нөлөөгөөр	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
4	Мал, амьтан үхэж, үрэгдэх	Нүх, суваг шуудуунд мал, амьтан унах	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
5	Мал, амьтны Бэлчээр хомсдох	Зам барих үйл ажиллагаанаас малын бэлчээр, зэрлэг амьтдын амьдрах талбай хомсдох	-1	1	1	2	1	1	1	-7	Бага
Дүгнэлт			Бага								

Төслийн үйл ажиллагааанаас хүн ам зүй, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Судалгааны талбайтай хамгийн ойр суурин газар нь Төв аймгийн Эрдэнэ сум (23км) болон Улаанбаатар хотын Налайх дүүрэг (35 км). Төв аймгийн Эрдэнэ суманд нийт 1291 өрхөд 3762 хүн амьдардаг. Хүн амын тоогоор Төв аймагтаа эхний тавд, газар нутгийн хэмжээгээр 1-д ордог ба хүн амын нягтрал 1 хүн/км2 байдаг. Энэ нутагт халх үндэстэн зонхилох ба ихэнх хэсэг нь нүүдлийн мал аж ахуй эрхэлж, цөөн тооны хүмүүс газар тариалан эрхлэн амьдардаг. Улаанбаатар хотын Налайх дүүргээс холгүй, 35 км зайтай, эндээс хэрэгцээт бараа материал, хүнс, төрөл бүрийн үйлчилгээг авах боломжтой.

Дэд бүтцийн хувьд Улаанбаатар-Сайншандын хатуу хучилттай автозамаас 18 км, Улаанбаатар-Замын-Үүдийн төмөр замын 9-р зөрлөгөөс 20 км зайд, Налайх-Багануурын 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам 20 орчим км зайтай, Өвөр Жанчивлангийн 10 кВ-ын дэд станц хүртэл 5 км, орд нь дэд бүтцийн маш таатай нөхцөлд байрлаж байна. Зам харилцааны хувьд жилийн аль ч улиралд авто хөсөг саадгүй зорчих боломжтой.

“Өгөөж их орд” ХХК-ийн Урт гозгорын цагаан тугалтган ордын төсөл хэрэгжсэнээр орон нутгийн нийгэм-эдийн засагт дараах нөлөөллийг үзүүлэх боломжтой. Нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийхдээ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын баталсан 2023 оны 58 дугаар тогтоолоор баталсан 2 дугаар хавсралтын дагуу болон оноот үнэлгээний аргаар үнэлэв.

Хүснэгт 13. Болзошгүй эерэг нөлөөлөл

Эерэг нөлөөлөл	Тайлбар
Ажлын байр нэмэгдэнэ	Орон нутгийн иргэд уурхай, дэд бүтэц, хамгаалалт, үйлчилгээзэрэгт оролцох боломжтой
Орон нутгийн төсөв өснө	Ашигт малтмалын төлбөр, ААНОАТ, НӨАТ, НДШ зэргээс орлого төвлөрнө
Бизнес идэвхжих	Бараа материал, хүнс нийлүүлэгч, тээвэр, жижиг үйлчилгээ эрхлэгчид шинэ боломж гаргана
Дэд бүтэц сайжирна	Эрчим хүч, зам, холбооны системд шууд ба шууд бус хөрөнгөоруулалт болно
Малчдад шинэ орлого бийболно	Түүхий эд нийлүүлэлт, хөдөлмөрийн зах зээлд оролцох шинэсуваг нээгдэнэ

Хүснэгт 14. Болзошгүй сөрөг нөлөөлөл

Сөрөг нөлөөлөл	Болзошгүй үр дагавар
Хүн амын шилжилт	Хөдөөнөөс ирж суурьших хүмүүсийн тоо өсч, суурин хүн ам нэмэгдэнэ
Нийгмийн үйлчилгээний ачаалал	Эмнэлэг, сургууль, ус хангамж зэрэг үйлчилгээ ачаалал авч болзошгүй
Үнийн хөөрөгдөл, инфляц	Үйлчилгээ, барааны үнэ нэмэгдэх эрсдэлтэй
Соёлын өөрчлөлт, орчны дарамт	Суурин болон нүүдэлчдийн амьдралын хэв маяг зөрчилдөх магадлалтай
Хүйсийн тэнцвэргүй байдал	Уул уурхайн салбарт эрэгтэйчүүд давамгайлснаар нийгмийн бүтэц өөрчлөгдөх эрсдэлтэй

Хүснэгт 15. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ

№	Болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийн хэлбэр	Нөлөөллийг үнэлэх үзүүлэлт								Нөлөөллийн түвшин
			Н	A_1	A_2	A_3	B_1	B_2	С	∑	
1	Ажлын байр нэмэгдэх	Орон нутгийн залуусын хөдөлмөр эрхлэлт сайжирна	+1	2	2	3	2	1	3	+13	Дунд
		Хөдөлмөрийн чадавхи өснө	+1	1	2	1	1	2	2	+9	Дунд
		Улирлын бус тогтмол орлого бүрдэнэ	+1	1	2	3	1	1	2	+10	Дунд
2	Орон нутгийн төсөвт орлого төвлөрөх	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, ААНОАТ, татвар, төлбөр хураамжийн хэлбэрээр төсөвт шууд орлого орно.	+1	2	2	3	3	2	2	+14	Их
		Дэд бүтэц, сургууль, цэцэрлэг, зам зэрэгт хөрөнгө оруулах боломж нэмэгдэнэ	+1	1	2	2	2	1	2	+10	Дунд
3	Худалдаа, үйлчилгээ, бизнесийн идэвхжил	Орон нутгийн жижиг бизнесүүд ашигтай ажиллах нөхцөл бүрдэнэ	+1	1	2	2	1	1	1	+8	Бага
		Тээвэр, түргэн хоол, дэлгүүр, авто засвар зэрэг орлого нэмэгдэнэ	+1	1	2	1	1	1	1	+7	Бага
		Иргэдийн хувийн орлого нэмэгдэнэ	+1	1	2	1	1	1	1	+7	Бага

4	Хүйсийн тэнцвэргүй байдал	Уул уурхайн салбарт эрэгтэйчүүд давамгайлснаар	-1	1	2	2	1	1	1	-8	Бага
5	Үнийнөсөлт	Барааны үнэ нэмэгдэх эрсдэл үүсэж болзошгүй	-1	1	2	1	1	1	1	-7	Бага
Дүгнэлт			Дунд								

Нийгмийн нөлөөллийн үнэлгээг дүгнэхэд нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь эмнэлэг, сургууль, ус хангамж зэрэг үйлчилгээ ачаалалтай болох, үйлчилгээ, барааны үнэ нэмэгдэх эрсдэл үүсэж болзошгүй, уул уурхайн салбарт эрэгтэйчүүд давамгайлснаар нийгмийн бүтэц өөрчлөгдөх эрсдэл үзүүлж болзошгүй байгаа бол нийгэмд үзүүлэх эерэг нөлөөлөл нь ажлын байр нэмэгдэх, орон нутгийн орлого өсөх, дэд бүтэц сайжрах зэрэг эерэг нөлөө үзүүлэхээр байна.

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсэгт болох агаарын чанар, усан орчин, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл, нөлөөллийн эрчим, цар хүрээг суурь судалгаа болон хээрийн судалгааны хэмжилтийн мэдээ, лабораторийн дээж шинжилгээнд үндэслэн тодорхойлсныг нэгтгэн доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 16. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгтгэл

Байгаль орчин	Нөлөөллийн эрчим, цар хүрээ					
	Эерэг			Сөрөг		
	Бага	Дунд	Их	Бага	Дунд	Их
Агаарын чанарт нөлөөлөх байдлын үнэлгээ	-	-	-	3	4	-
Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид нөлөөлөх байдлынүнэлгээ	-	-	-	3	4	-
Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөх байдлын үнэлгээ	-	-	-	1	3	-
Ургамлан нөмрөгт нөлөөлөх байдлын үнэлгээ	-	-	-	1	3	-
Амьтны аймагт нөлөөлөхбайдлын үнэлгээ	-	-	-	3	2	-
Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын үнэлгээ	3	4	1	2	-	-

Нийт	3	4	1	13	16	-
Дүгнэлт	Нийт үнэлгээний 21.6% нь эерэг, 78.4% нь сөрөг байгаа бол үүнээс 44.44% нь бага зэрэг сөрөг, 55.1% нь дунд зэрэг сөрөггэсэн ангилалд байгааг үндэслэн уг төслөөс байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг “ДУНД” гэж үнэлсэн.					

БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний үндсэн зорилго нь төслийг хэрэгжүүлэх явцад үүсэх бүхий л сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Төслийн үйл ажиллагаанаас төсөл хэрэгжих бүс нутгийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг нөлөөллийг илрүүлэх, тэдгээрийн үр дагаврыг хянах үүрэгтэй.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дэвсгэрт байрлах “Урт гозгорын цагаан тугалгын ордыг ил аргаар ашиглах” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардал, дагаж мөрдөх дүрэм журам, стандартуудыг нэгтгэн үзүүлсэн бөгөөд төсөл хэрэгжүүлэгч төслийн хэрэгжүүлэх нийт хугацаанд энэхүү үнэлгээгээр тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд, тэдгээрийг арилгах бууруулах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах үүрэгтэй.

- БОМТ-ын үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана. Үүнд:
- БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх;
- БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах зэрэг нөхцөлүүдийг тодорхойлно;

Уг төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй нөлөөллүүд дээр үндэслэн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан болно. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, БОМТ-ний хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, зэрэг ажлууд багтсан.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь:

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
- Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ.

Энэхүү байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө /БОХТ/ нь төлөвлөж буй төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүн амд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдээс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнүүдийг шаардагдах хөрөнгө зардал, хугацаа, давтамж, баримтлах дүрэм журам, стандартуудын хамт нэгтгэн үзүүлж буй төслийг хэрэгжүүлэгч “Өгөөж их орд ” ХХК-аас заавал хэрэгжүүлж, мөрдөж ажиллах ёстой баримт бичиг юм.

“Өгөөж их орд” ХХК-ийн нь 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль хамгаалах хууль тогтоомж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүн, батлагдсан байгаль орчны менежментийн төлөвлөгөө (5 жил)-нд үндэслэн боловсруулав.

БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОННҮ-ний тайланд төслийн цар хүрээнд бий болох сөрөг нөлөөллийн эрчим нь багаас дунд түвшинд хэлбэлзэх бөгөөд сүйрлийн хэмжээнд хүрэх ноцтой сөрөг нөлөө үзүүлэхгүй. Энэ нь төсөл хэрэгжүүлэх нутгийн байгаль, газарзүйн байршил, байгалийн нөөцийн нөхөн сэргэх чадавхтай холбоотой байх тул сөрөг нөлөөллийг бууруулах, улмаар арилгах боломжтой байна. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг төлөвлөхдөө ТЭЗҮ-д тусгагдаагүй, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрээр авч үзлээ..

Хүснэгт 17. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмж ээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	Замын хөдөлгөөны аюулгүй байдал аваар осол гарч болзошгүй.	Уурхайн зам талбайд тэмдэг тэмдэглэгээ нэмж байршуулах	Уурхайн дотоод замын шаардлагатай хэсгүүдэд байршуулах	ш	60,0 төг	15	1500,0	6-8 сард байршуулна	MNS4585:2007 (Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага) -MNS3383:1982 (Агаар мандал, Бохирдлын эх үүсвэр, нөхцөл байдал ба тодорхойлолт)
2	Хөрс хуулалт, барилга байгууламж барих, олборлох, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсэж төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлнө.	Уурхайн авто замуудыг болон олборлолтын талбайн тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх	Уурхайн зам, олборлолтын талбай	M^3	0,2	$4000м^2$	4000,0	Өдөр бүр	
4		Уурхайн талбай дахь замын сүлжээг сайжруулан шороон зам дагтаршуулан засах	Уурхайн дотоод зам	-	-	7000,0	7000,0	5-7 сард	
5	Агаарын чанарт, тоосжилтийг хэмжих	Төв аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төв, Байгаль орчны шинжилгээний лабораторид хандаж төслийн талбайгаас дээж авах	Уурхайн талбайд	Удаа	ОХШзардалд тусгаса	тээвэрлэлтийн зам, уурхайн кемп	ОХШзардалд тусгаса	Улиралд 1 удаа	
6	Агаар бохирдох, тээврийн	Техник хэрэгслийг үзлэг, оношилгоонд	тээврийн	Ш	ҮАЗ		--	Жилд 1 удаа	-MNS5885:2008 (Агаар бохирдуулагч бодисуудын хүлээн зөвшөөрөгдсөн концентрац, Техникийн

	хэрэгслийн утаа, хог хаягдал зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй	оруулах	автомашинууд						ерөнхий шаардлага)
Усны нөөц, чанар									
1	Уурхайн үйл ажиллагааны улмаас газрын доорх усны түвшин буурах	Ус ашигласны төлбөрийн цаг тухайд төлж барагдуулж байх			42,057	42,057	42,057	1 удаа	MNS3308:1991
2		Булгын эх хаших	Төслийн талбай	М3	15000	1	15000	1 удаа	
4	Усны шинжилгээ Газрын доорх усны бохирдолоос сэргийлэх	Төв аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төв, Байгаль орчны шинжилгээний лабораторид хандаж төслийн талбайгаас дээж авч шинжилгээ хийлгэх	Төслийн талбай				ОХШ зардалд тусгагдсан	2026	усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх
Хөрсөн бүрхэвч болон газрын гадарга									
1	Төслийн үйл ажиллагааны улмаас газрын гадарга, хөрс эвдрэх, ургамлан бүрхэвч устах хөрс хог хаягдлаар бохирдох	Ашиглалтын явцад зөвхөн технологийн замуудыг байгуулан, маршрутыг тогтоож, онц шаардлагагүй олон салаа зам гарч газрын гадарга эвдэгдэхээс сэргийлэх	Төслийн талбай	Өдөр тутам хяналт тавих	YAЗ		--	2026	Хөрс Хөрсний химийн элемэнтүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
2	Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх боломжгүй болох	Шитм хөрсний овоолго стандартын дагуу үүсгэж тэмдэгжүүлэх	Төслийн талбай	$М^3$	1000$м^3$	- YAЗ		Үйл ажиллагааны турш	MNS 3307:1991, MNS3308:2019 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх

									дээд хэмжээ
3		Асгаралтаас урьдчилан сэргийлэх асгаралтын иж бүрдлийг авах	Төслийн талбай	ширхэг	1500,0	2	3000,0	2026 онд	Уда а Удаа Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5916:2008
4		Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд даган мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	Төслийн талбай	Тухай бүрд	--	УАЗ		Тухай бүрд	
5	Хөрсөн бүрхэвч бохирдох	Төв аймгийн ус цаг уур, орчны шинжилгээний төв, Байгаль орчны шинжилгээний лабораторид хандаж төслийн талбайгаас дээж авч шинжилгээ хийлгэх	Төслийн талбай	удаа	--	--	ОХШ зардалд тусгагдсан	Улиралд 1 удаа	Хөрс хамгаалал цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Ургамлан бүрхэвч, зэрлэг ан амьтан болон мал сүрэгт									
1	Түр кемпийн талбай дээр	Явган хүний зам хийх	Кемп	М1500	2500	--	2500		
Амьтны аймаг									
2	Амьтны аймагт авч хэрэгжүүлэх арга хэмжээ	**Биотехнидийн арга хэмжээ авхад орон нутагтай хамтран ажилах**	Төслийн талбайн ойр орчимд	ш	11,0	50	5000,0	Өвлийн улиралд	
Нийт							**66,557.0**		

БҮЛЭГ 6. НӨХӨН СЭРГЭЭЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны хувьд олборлолтын эхний жил учираас уурхайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй.

Хүснэгт 18.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж зардал /төгрөг/	Нийт зардал /төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн бичиг
1	Техникийн нөхөн сэргээлт	2026 онд техникийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй.	x	x	x	x	x	x
2	Биологийн нөхөн сэргээлт	2026 онд биологийн нөхөн сэргээлт төлөвлөгдөөгүй.	×	×	×	×	×	×

БҮЛЭГ 7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ , ТЭРБУМ МОДНЫ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ


7.1 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөндөө сум, орон нутгийн заасан талбайд мод тарих ажлыг хийж гүйцэтгэнэ.

Хүснэгт 19. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
1	Ногоон байгууламж нэмэгдүүлэх	Мод тарих Эрдэнэ сумын нийтийн эзэмшлын талбайд	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр	1000	10000,0	5-р сард
	Нийт				10000,0	

Зураг 3. Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд мод тарих талбай



7.2 Тэр бум мод үнэдсэний хөтөлбөрийн хүрээнд

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнтэй холбоотойгоор Эрдэнэ суманд 500 мод тарихаар төлөвлөлөө.

Хүснэгт 20. Тэрбум модны зардал

Материалын нэр		Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ, төг	Нийт үнэ, мян.төг
1	Голт бор	ш	250	10000	2500,0
	Агч мод	ш	250	10000	2500,0
Нийт					5000,0

Зураг 4. Тэрбум модны хүрээнд мод тарих талбай



БҮЛЭГ 8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төсөл хэрэгжиж буй газар нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг буюу айлын өвөлжөө хаваржаа байхгүй суурьшлын бүсэд хамаарахгүй. Иймд төслийн ойр орчимд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ төлөвлөх шаардлагагүй.

БҮЛЭГ 9. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны явцад түүх соёлын өвийг хамгаалах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд: Соёлын өвийг хамгаалах, хадгалах Монгол улсын хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх

Төслөөс шууд өртөж нөлөөлөгдөхөөргүй цэгүүдийг хамгаалах ажиллагаа, соёлын ба үнэт өв дурсгалтай газрыг хамгаалах төлөвлөгөө,хөтөлбөрийг боловсруулахдаа төв, орон нутгийн удирдах байгууллага,мэргэжилтнүүд,орон нутгийн олон нийтийн байгууллага, ШУА-ын Археологийн Хүрээлэн зэрэгтэй зөвлөлдөнө.Энэ төлөвлөгөө, хөтөлбөрийг төслийн бүтээн байгуулалт эхлэхээс өмнө төлөвлөж мөрдөх.

Хүснэгт 21.Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
Төсөл хэрэгжиж буй талбайд шинээр археологи, палеонтологийн олдвор гарсан тохиолдолд	Мэргэжлийн байгууллагуудтай хамтран нүүлгэн шилжүүлэх, музей эсвэл эрх бүхий төрийн байгууллагад шилжүүлэнэ.	Олдвор олдсон тохиолдолд	300 000	300 000	Олдвор олдсон тохиолдолд	Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу
Нийт дүн			300 000 төг			

БҮЛЭГ 10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны техник технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгаж хянах, ажилчдын хөдөлмөр хмагаалалтын хувцас хэрэгслээр хангаж ажилана. Галын сарай болон анхааруулах тэмдэг тэмдэглэгээ байршуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 22. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Болзошгүй осол, саатал, химийн бодис асгарах, техник технологийн дуу чимээ, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Уурхайн бүх обьектод хамаарна.	--	Үйл ажиллагааны зардалд орно.		7 сард	ОБЕГ-ын даргын 2016 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/75 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт
2	Ажилчид гэмтэж бэртэх	Ажилчдыг хөдөлмөр хамгаалалтын хэрэгслээр хангаж ажиллах	Бүх ажилчид	40ш	Үйл ажиллагааны зардалд орно.		2025 онд	
		Ослын үед болон шаардлагатай үед ажилчдад цаг алдалгүй эмнэлгийн анхны тусламж үзүүлэх анхны тусламжийн эмийн санг бэлдэх	Төслийн талбайд	3	500,0	1500,0	Байнга бэлэн байх	

3	Гал түймэр гарах	Төслийн талбайд галын хор байршуулах	Кемп, үйлдвэр, засварын цэгт	4 ш	25,0	100,0	Улиралдаа 1 удаа цэнэглэх	
4	Ажилчдын хайхрамжгүй үйлдлээс болж осол гарах	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалт явуулах	Бүх ажилчид	Өдөр бүр	ХААБ мэргэжилтэн		Өдөр бүр	
5	Авто ослоос сэргийлэх	Анхааруулах тэмдэглэгээг сэргээх	Төслийн талбайд	20	20	400,0	6-7 срад	MNS ISO 31010:2016
6	Гал түймэр гарах	Галын сарай	Төслийн талбай	2	1500,0	3000,0	2026 онд	Осол эрсдлийн үнэлгээ
7	Ажилчид хордох	Ажилчдад хор тайлах бүтээгдэхүүн олгож байх /витаминжуулсан ундаа, сүү/	Үйл ажиллагааны хүрээнд	ҮАЗ			Өдөр бүр оронй хоолон дээр	
8	Гал түймрээс урьдчилан сэргийлэх	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Үйл ажиллагааны мхүрээнд	2	250,0	500,0	Жилд 2 удаа	Хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм журам
Нийт						5500,0		

БҮЛЭГ 11. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежмент гэдэг нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлын эх үүсвэрийг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах бүхий л процессыг хянаж сайжруулах зохион байгуулалтын арга хэмжээ юм.

Эзэмшил газрынхаа ойр орчны цэвэрлэгээг тогтмол хийх, үйл ажиллагааны явцад үүсэх хог хаягдлыг тогтоосон цэгт хуримтлуулж тогтмол хугацаанд зайлуулах, ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хаягдлыг ашиглах, аливаа зүйлээр бохирдсон хог хаягдлыг саармагжуулах, галын аюулаас хамгаалах, хадгалалт хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Төсөл хэрэгжүүлэгч нь хог хаягдлын менежментийн хүрээнд цаашдын авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх, хог хаягдлыг газар дээр нь ангилан ялгах нөхцөл бололцоог хангаж ажиллах үүрэгтэй.

Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хадгалахдаа хогийн сав болон хогийн цэгийг өнгөөр ялгаж зургаар тэмдэгжүүлснээр хуурай хог хаягдлыг стандартын дагуу ачиж, тээвэрлэх хадгалах нөхцөл бүрдэхээс гадна байгаль орчинд сөрөг нөлөөгүй бохирдолгүй амьдрах нөхцөл бололцоо бий болох юм.

Төслийн үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдал гарах ба тус бүрд нь тохирсон арга хэмжээг авч ажиллахдаа төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох хог хаягдал хэмжээг гэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах 4R зарчмыг баримтлан ажиллах шаардлагатай. Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад доорх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

Хүснэгт 23. ***Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө***

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах	Хог хаягдлын гэрээг Эрдэнэ сумын ЗД-тай байгуулах төлбөр төлөх	Төслийн хэмжээнд	удаа	120,0	12	УАЗ	2026 он	Хог хаягдлын тухай хууль
2	Хатуу болон шингэн хог хаягдал	Хуванцар сав цуглуулах сав байршуулах	Төслийн хүрээнд	ш	300	5	1500.0	2026 он	

3		3 тасалгаатай ангилан ялгах хогын сав нэмж байршуулах	Төслийн хүрээнд	ш	300	2			
4	Шингэн хаягдал	Бохир ус соруулдаг байгууллагаар соруулан зайлуулах	Эко нойл	3	300,0	удаа	900	Жилд 2 удаа	Хог хаягдлын тухай хууль
5	Аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумляторыг тусгай цэг гарган төслийн талбайд 150 хоног хадгалан дахин ашиглах цэгт хүргүүлж байх	Засварын газарт	ш	1080,	1	1080,0	2026 он	Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
6	Аюултай хог хаягдал	АХХ гэрээ байгуулан мэрэгжлийн байгууллагатай хамтран ажиллах	Төслийн үйл ажиллагаа	удаа	1200,0	1	YAЗ	2026	
7	Жорлон, ариун цэврийн өрөө	Ажилчдын ариун цэврийн өрөө, жорлонг Тамир эм бэлтмэдийн ариутгалын бодисоор ариутгах	Эко нойл	удаа	200,0	Жилд 2 удаа	400.0	6, 8, сард	Хог хаягдлын тухай хууль
8	Ахуйн хог хаягдал	Хог хаягдлын түр хадгалах цуглуулах цэгээ сайжруулах	Түр хадгалах цэг	ш	500,0	1	500,0	5 сард	
		Нийт					**4380.0**		

БҮЛЭГ 12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Өгөөж их орд” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Урт гозгорын цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах” төслөөс байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан баримт бичиг юм.

ОХШХ нь БОХТ-тэйгээ нягт уялдсан байх ба байгаль орчныг хамгаалах арга хэмжээний үр дүнг илэрхийлнэ. Мөн төслийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээнүүд нь үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу төсөл батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 дугаар сарын 01-ний дотор БОУАӨЯ-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг төсөл хэрэгжүүлэгч хариуцах болно.

Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад БОМТ-ний тайланд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор зайлшгүй хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт

Зураг 5. Төслийн талбай дахь мониторингийн цэг



Хүснэгт 24. 2026 онд хэрэгжүүлэх орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
Агаарын чанар	Хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоос	Ажлын байранд, Тээвэрлэлтийн замын дагуу Ил уурхай	жилд 4 Удаа * 3 цэг	300,0	жилд 4 Удаа * 3 цэг НИЙТ 3,000.0	– MNS 4585:2016 Агаарын чанар. – Техникийн ерөнхий шаардлага – - Агаарт байх бохирдуулах бодисын – хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий – шаардлага – - MNS 3113:1981 Агаар мандал. – Агаарын бохирдуулах бодисыг – тодорхойлох аргад тавигдах ерөнхий – шаардлага
	Ажлын байрны дотоод орчны агаарын шинжилгээ хийлгэх	Ажилчдын байр, Ил уурхай	Агаар дахь хорт бодис	300,0	жилд 4 удаа * 2 цэг НИЙТ 3000.0	MNS 4990:2023 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны агаар дахь хорт бодисыг хэмжихэд тавих ерөнхий шаардлага, зөвшөөрөх дээд хэмжээ.
Хөрсөн бүрхэвч	Хөрсний хими физик шинж чанар, шинжилгээг хийлгэх	Мониторингийн цэг, хог хаягдлын цэг	Жилд 4 удаа, 8 цэгт	50,0	500,0	– MNS3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл – MNS3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох – MNS2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам – MNS(ISO)4814:1999. Атом Шингээлтийн Спектрометрээр шинжилгээ хийх

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
	Хүнд металлын шинжилгээ хийлгэх	Ахуйн, шатах тослох материалын хог хаягдлын цэг, хаягдлын далан	Жилд 4 удаа, 4 цэг	200,0	3200,0	– MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд – дээж авахад тавигдах ерөнхий – шаардлага – - MNS 3675:1984 Хөрсний органик – бодисын хэмжээг тодорхойлох – лабораторийн арга – - MNS 7050:2008 Хөрс бохирдуулагч – бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх – дээд хэмжээ
	Нянгийн шинжилгээ хийлгэх	Мониторингийн 1 цэг, ахуйн бохир цэвэрлэх байгууламж орчим	Жилд 2 удаа 2 цэгт	200,0	3200,0	
Усан орчин	Усны ерөнхий шинжилгээ	Унд ахуйн уснаас	Жилд 4 удаа, гүний 1 худгаас дээжлэлт хийж лабораторийн шинжилгээнд өгч	200,0	2400,0	– MNS0900:2005 Ундны ус-Ундны усны хяналт шинжилгээ – MNS3935:1986 Ундны ус-Усны шинжилгээнд тавигдах шаардлага – MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх – MNS4432:1997 Ундны ус-Хуурай үлдэгдлийн хэмжээг тодорхойлох – MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх
	Химийн шинжилгээ	Унд ахуйн уснаас	Жилд 4 удаа	200,0	2400,0	
	Микробиологийн шинжилгээ	Унд ахуйн уснаас	Жилд 4 удаа	200,0	2400,0	

Бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал мян.төг/жил	Баримтлах стандарт ба арга аргачлал
	Саарал ус	Ахуйн бохир	Жилд 2 удаа	200,0	400,0	
	Дээж хэмжилт авах ажлын зардал, томилолт		4 удаа	500.0	2000	–
	Нийт				**9900.0**	

БҮЛЭГ 13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөнд Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 1 удаа сургалт, сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн. 8-р саруудад хийсэн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн хэмжилт дээжлэлтийн үр дүнг Эрдэнэ сумын иргэд танилцуулах санал зөвлөгөөг сонгох зорилгоор 9-р сард уулзалт зохион байгуулахаар төлөвлөсөн.

Хүснэгт 25. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, төг	Хариуцагч
1.	Газрын төлбөр төлөх	2026 онд	ҮАЗ	Гүйцэтгэх захирал захирал
2	Ус ашиглах гэрээ байгуулах	2026 онд	ҮАЗ	БОМ
2.	Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг байгаль орчны газарт хүргэн өгч байх	1 жилд 1 удаа	Дотоод төлөвлөлтөөр	БОМ
4.	Байгаль орчныг хамгаалах талаар сургалт орох	-	-	БОМ
5.	Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулж, хамруулах	-	500,0	Компанийн захирал
Дүн			**500,0**	

БҮЛЭГ 14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Тухайн жилийн биелэлтийн тайланг 2026 оны 11-р сарын 1-ны өдөр аймгийн байгаль орчны газар болон Эрдэнэ сумын БО улсын байцаагчид хүргэн өгөхөөр төлөвлөсөн.

Хүснэгт 26. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа

Хугацаа	Нөлөөлөлд өртөгч оршин суугчдад танилцуулах ажил	Зардал	Зохион байгуулах хүний албан тушаал
2026.10 сард	Эрдэнэ сумын ИНХурлын дарга, төлөөлөгчид, Засаг дарга, холбогдох бусад байгууллага болон нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчид	150000+100000=250 000төг	БОМ-Уурхайн дарга
2026.11.01	Төв аймгийн байгаль орчны газар 11 сарын 01 ний дотор	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	БОМ, Уурхайн дарга
Нийт зардал		250 000 төг	

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ, ДҮГНЭЛТ

“Өгөөж их орд ” ХХК-ийн Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж буй “Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыгил аргаар олборлох” MV-020756 ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг БОУАӨ-ийн яамны ерөнхий үнэлгээний дүгнэлт, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх журам, аргачлалд үндэслэн хийж гүйцэтгэлээ.

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт “Өгөөж их орд” ХХК-ийн MV-020756 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах төслийн ашиглалтын 5 жилийн БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, мөн сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Хүснэгт 27. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нэгдсэн хүснэгт

№	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний ажлын зардал	66,557,0
2	Нөхөн сэргээлтийн ажлын зардал	-
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	10000,0
4	Тэрбум мод хөтөлбөрийн зардал	5000,0
5	Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний төсөв	300.0
6	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5500,0
7	Хог хаягдлын менежментээр хийгдэх ажлын зардал	4380.0
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал	9900.0
9	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	500.0
10	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардлын задаргаа	250,0
	байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн	**118,712**
	Байршуулах барьцаа мөнгө	59,356

2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **118 712 000** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн барьцаа мөнгө болгож 59,356,000 төгрөгийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9,15 дахь заалтанд зааснаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалын дагуу Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн баталгааны тусгай Төрийн сангийн 780090100900013406 тоот дансанд байршууллаа.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. БОНХЯ, “Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх аргачлал” УБ., 2014.04.10
2. БОНХЯ, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлал” УБ., 2019.10.29
3. БОНХЯ “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал” 2014 он
4. БОАЖЯ., “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар”, УБ., 2010
5. Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал. – УБ, 2012.
6. Химийн хорт болон аюултай бодис. Гарын авлага. Эмхэтгэсэн: Л.Жаргалсайхан, Б.Алтангадас. – УБ, 2010, - 397 х.
7. Монгол Улсын Шадар сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 54/А/136/А/215 дугаар хамтарсан тушаалын хавсралт Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам,
8. Байгаль орчны хуулиудын эмхэтгэл, 2009
9. ШУА, Газарзүйн хүрээлэн., “Улаанбаатар хотын хөрсний бохирдол” тайлан УБ. 2013
10. БО-ны хэмжилзүйн төв лабораторийн гадаргын усны чанарын хяналтын мэдээ
11. Доржготов.Д нар., Монгол улсын үндэсний атлас, УБ. 2009
12. БНМАУ-ын үндэсний атлас УБ. 1990. 73 х
13. Жамбаажамц.Б., Монгол орны уур амьсгал. УБ. 1989. 269 х
14. Нестеров.В.Е. Вопросы управления природой. М., “Лесная промышленность” 1981 14. Орчны үнэлгээний арга зүйн асуудал, Мижиддорж Р. нар, редактор Б.Баясгалан УБ., 2002
15. Саран.Б, Чинзориг.Г. Усны тухай хууль тогтоомжийн эмхэтгэл УБ., 2008
16. Русин И.И. Экологизация экономики: методы регионального управления. М., 1990 17. Чинзориг.Г, Гадаргын усны бохирдол, 2008
17. “Экологи – тогтвортой хөгжил” эмхтгэлүүд 1997-2001
18. Environment Impact Assessment. Guidelines for Mining Development UN. New York. 1999
19. Jain, L.V.Urban. Environment Assessment. USA. 1993
20. www.geodata.mne.mn
21. www.sciencelab.com
22. www.mne.mn
23. www.icc.mn

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

1. “Өгөөж их орд” ХХК–ийн аж ахуй нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөл, /MV-0 20756/
3. Кадастрын лавлагаа
4. Техник эдийн засгийн үндэслэл
5. Уул уурхай, хүнд үйлдвэрийн

яам ашигт малтмал, газрын тосны газар эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт

6. Үндэсний геологийн албаны даргын тушаал /Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай/
7. Тойрох /Ашигт малтмалын орд ашиглах ТЭЗҮ хэлэлцэх ЭМБЗ-ийн салбар хуралдаанаар засварлуулахаар шийдвэрлэсэн ТЭЗҮ/
8. Ой усан сан бүхий газартай давхцалтай эсэх лавлагаа
9. Багийн иргэдийн нийтийн хурлын тогтоол
10. БОУАӨЯ-ны ерөнхий үнэлгээний дүгнэлт
12. Ус ашиглах боломжит нөөцийн дүгнэлт
13. Хайгуулын ажлын үр дүнгийн тайлан
14. Хөрсний задлан шинжилгээний дүн мэдээ
15. БОННҮ-ний мэргэжлийн байгууллагын УБ-ын гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн хуулбар

ХАВСРАЛТ

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

000368342

2019.11.13 / Бүртгэсэн он,сар,өдөр /

9019099652 / Хувийн хэргийн дугаар /

6496148 / Регистрийн дугаар /

Гадаадын хөрөнгө оруулалттай хязгаарлагдмал хариуцлагатай компани / Хуулийн этгээдийн нэр, хэлбэр /

Өгөөж их орд

Дүрэм / Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр / шийдвэрийн нэр /

01 / Дугаар /

2019.11.12 / он, сар, өдөр /

49230	Авто машинаар ачаа тээвэрлэх
16530	Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа
72101	Уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх
77300	Хүнд машин механизмын түрээсийн үйлчилгээ
46100	Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа
09901	Ашигт малтмал /2022.06.30-2047.01.19/
46590	Хүнд машин механизмын тоног төхөөрөмжийн худалдаа

/ Код/ / Үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй / хугацаа /

2 / гишүүдийн тоо /

511,550.00 / хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Хан-Уул, 17-р хороо, 7 хэсэг, их монгол улс, ривер гарден, 405, 803 тоот, Утас1: 99966101, Утас2: , Факс: / хуулийн этгээдийн албан ёсны хаяг/

ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГАЗАР / Бүртгэсэн байгууллагын нэр /

УЛСЫН БҮРТГЭГЧ /гэмдэг/ Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ /гарын үсэг/

Гэрчилгээ дахин олгосон 2026 он 05 сар 12 өдөр

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Нарантунгалаг овоотой Дашнамжил-г Гүйцэтгэх захирал -р сонгосон(томилсон)-ыг бүртгэв.	2026.05.12	Д.Эрдэнэцэцэг
2	Дахин гэрчилгээ олгов.	2026.05.12	Д.Эрдэнэцэцэг

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

000368342

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

АШИГТ МАЛТМАЛ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ

ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар ***MV-020756***

Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн

Төв аймаг /хот/-ийн

Эрдэнэ сум /дүүрэг/-ын

Урт гозгор нэртэй газарт орших

243.40 гектар талбай бүхий уурхайн талбайд хуульд заасан нөхцөл, шаардлагын дагуу ашигт малтмал ашиглахыг зөвшөөрч улсын бүртгэлийн ***1911020023*** тоот гэрчилгээтэй

“Зов газар элемент” ХХК -д

энэхүү тусгай зөвшөөрлийг ***2047.01.19*** дуустал хугацаагаар олгов.

Тусгай зөвшөөрөл хавсралттүй бол хүчингүй.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Д.МӨНХТАМИР

2017 оны 1 сарын 19 өдөр

Улаанбаатар хот

0000051

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-020756

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
001-NM	• Бүртгэв: Ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон 2017.01.19, дуусах хугацаа 2047.01.19 • Тусгай зөвшөөрлийн 1 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв • Кадастрын хэлтсийн даргын 2017.01.13-ний 31 тоот шийдвэр	1 АМГТГ ... 2017.01.19
002-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 2 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2018.01.19 – 2019.01.19 хүртэл	1 АМГТГ ... 2018.01.16
003-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 3 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2019.01.19 – 2020.01.19 хүртэл	1 АМГТГ ... 2019.01.21
004-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 4 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2020.01.19 – 2021.01.19 хүртэл	1 АМГТГ ... 2020.01.20
005-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 5 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2021.01.19 – 2022.01.19 хүртэл	1 АМГТГ ... 2021.01.25
006-CN	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн нэрийг 1911020023 тоот улсын бүртгэлийн дугаартай Зов газар элемент ХХК болгон өөрчлөх. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын тодорхойлолтыг үндэслэн компаний оноосон нэрийг өөрчлөв. • Кадастрын хэлтсийн даргын 2021.01.21-ний --- тоот шийдвэр	1 АМГТГ ... 2021.01.25
007-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 6 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2022.01.19 - 2023.01.19 хүртэл	1 АМГТГ ... 2022.01.12

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

MV-020756

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Огноо, гарын үсэг, тэмдэг
008-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 7 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2023.01.19 – 2024.01.19 хүртэл	1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2023.01.18
009-CN	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн нэрийг 9011781121 тоот улсын бүртгэлийн дугаартай Зөв газар элемент ХХК болгон өөрчлөх. Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын тодорхойлолтыг үндэслэн компаний оноосон нэрийг өөрчлөв. • Кадастрын хэлтсийн даргын 2023.12.01-ний --- тоот шийдвэр	1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2023.12.28
010-FE	• Бүртгэв: Тусгай зөвшөөрлийн 8 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2024.01.19 – 2025.01.19 хүртэл	1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2023.12.28
011-FE	• Баталсан: Тусгай зөвшөөрлийн 9 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2025.01.19 – 2026.01.19 хүртэл	1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2025.02.03
012-TF	• Баталсан: Тусгай зөвшөөрлийг 5745721 тоот улсын бүртгэлийн регистрийн дугаартай Литиум сенчури ХХК-д шилжүүлэх • Кадастрын хэлтсийн даргын 2025.08.07-ний/ны 440 дугаартай шийдвэр	4 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2025.08.07
013-TF	• Баталсан: Тусгай зөвшөөрлийг 6496148 тоот улсын бүртгэлийн регистрийн дугаартай Өгөөж их орд ХХК-д шилжүүлэх • Кадастрын хэлтсийн даргын 2025.12.02-ний/ны 631 дугаартай шийдвэр	4 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2025.12.02
014-FE	• Баталсан: Тусгай зөвшөөрлийн 10 дахь/дэх жилийн төлбөрийг төлөв. Хугацаа 2026.01.19 – 2027.01.19 хүртэл	1 АМГТГ КАДАСТРЫН ХЭЛТЭС ХТО7043 2026.01.19

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ 2 ДУГААР ХАВСРАЛТ

MV-020756

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээгүй бол хүчингүй.

Дэс дугаар	Тусгай зөвшөөрөлд орох өөрчлөлтийн үндэслэл	Хүчин төгөлдөр талбайн хэмжээ /га/	Хасагдах талбайн хэмжээ /га/	Тусгай зөвшөөрлийн талбайн солбицлууд, огноо, гарын үсэг, тэмдэг		
				#	Уртраг	Өргөрөг
001-NM	• Ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх олгосон 2017.01.19	243.4 Га	0 Га	1 2 3 4 2017-01-19	107° 34' 0.11" 107° 33' 1.42" 107° 33' 1.42" 107° 34' 0.11"	47° 34' 7.51" 47° 34' 7.51" 47° 35' 11.76" 47° 35' 11.76"

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР

Засгийн газрын XII байрны баруун жигүүр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 36 28, Факс: (976-11) 31 03 70,
Цахим шуудан: info@mrpam.gov.mn,
Цахим хуудас: mrpam.gov.mn

2025.12.02 № 10/6059

танай _____-ны № _____-т

"ӨГӨӨЖ ИХ ОРД"
ХХК-Д

Шийдвэрийн дагуу мэдэгдэл
хүргүүлэх тухай


"Литиум сенчури" ХХК-ийн Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Урт гозгор нэртэй 243.40 гектар талбай бүхий MV-020756 тоот тусгай зөвшөөрлийг шилжүүлэх өргөдлийг TR-009583 дугаарт бүртгэн хянаж үзээд Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсэгт заасныг үндэслэн Кадастрын хэлтсийн даргын 2025 оны 12 дугаар сарын 02 -ны өдрийн 631 дүгээр шийдвэрээр (тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайн булангийн цэгүүд хэвээр) танай компанид шилжүүлснийг бүртгэж, тусгай зөвшөөрлийн хавсралтад тэмдэглэгээ хийснийг мэдэгдье.

КАДАСТРЫН ХЭЛТСИЙН
ДАРГА М.ЭНХТУЛГА

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ

ЛАВЛАГАА

Тусгай зөвшөөрлийн дугаар: 20756



ТАНИХ ТЭМДЭГ

Ашиг малтмалын тусгай зөвшөөрөл

Ашиглалтын

Хайгуулын

Засаг захиргааны хил

Улсын хил

Аймгийн хил

Сумын хил

Аймгийн төв

Сумын төв

Тусгай хамгаалалттай газар нутаг

Дархан цаазат газар

Байгалийн цогцолборт газар

Байгалийн нөөц газар

Дурсгалт газар

Хамгаалалтын бүсүүд

Гол мөрний урсац бүрхлэх эх

Ойн сан бүхий газар

Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс

Онцгой хамгаалалтын бүс

Энгийн хамгаалалтын бүс

Ус хангамжийн эх үүсвэр

Эрүүл ахуйн хориллолтын бүс

Эрүүл ахуйн хяналтлалтын бүс

Тэжээгдлийн муж

Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Орон нутгийн усны хамгаалалтын бүс

Масштаб 1:17955.0

Аймаг, сум, сав газрын нэр: Төв аймаг Эрдэнэ сум, Хэрлэн голын сав газар

Засгийн газрын 2012 оны 194, 2015 оны 289-р тогтоолоор батлагдсан гол, мөрний урсац бүрэлдэх эхтэй давхцалгүй, ойн сантай давхцалгүй, усны сан бүхий газрын хамгаалалтын бүстэй давхцалгүй, улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна. Орон нутгийн усны энгийн болон онцгой хамгаалалтын бүстэй давхцалгүй байна.

Огноо: 2025-03-25

Лавлагаа хүссэн огноо:2025-03-25 1/1

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

УСНЫ АШИГЛАХ БОЛОМЖИТ НӨӨЦИЙН ДҮГНЭЛТ

оны -р сарын -ны өдөр

Дугаар E-2503-000209

1.Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:

Байгууллагын нэр:	Зөвгазар элемент ХХК
Улсын бүртгэлийн дугаар:	
Регистрийн дугаар:	4270177
Захирал:	Балдан Сарантуяа
Холбоо барих утасны дугаар:	99966101

2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:

Байгууллагын нэр:	Дээшлэх говь ХХК
Холбоо барих утасны дугаар:	99103664

3. Төслийн нэр, байршил:

Төслийн нэр:	Цагаан тугалганы шороон ордыг ил аргаар ашиглах төсөл
Байршил:	Төв, Эрдэнэ, 5-р баг, Тамган
Харьяалагдах сав газар:	Туул голын сав газар
Хамаарах салбар:	Уул уурхай

4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:

Дугаар	Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт
MV-020756	АМГТГ-аас Төв аймгийн Эрдэнэ сумын "Урт гозгор" нэртэй газарт 243.4 га талбайг ашигт малтмал ашиглалтын 30 жилийн хугацаатай олгосон.

5. Төслийн хүчин чадал, ажиллах горим:

Төслийн хүчин чадал:	Ордоос хоногт 342.1 тн элс, жилд 65.0 мян.м3 элсийг олборлон гравитацийн аргаар баяжуулж 61.02%-ийн агуулгатай цагаан тугалганы баяжмал гарган авч, экспортлоно.
Төслийг хэрэгжүүлэх нийт хугацаа (жил):	3
Ажлын горим:	2 ээлжээр
Жилд ажиллах хоногийн тоо:	190
Жилд ажиллах хүний тоо:	48

6. Усны нөөц, усны эх үүсвэр:

Эх үүсвэр	Нэр	Зориулалт	Усны нөөц (л/сек)	Усны нөөц (м3/хон)	Байршил (X, Y)	Тайлбар
Гүний худаг	Худаг-1	Технологийн хэрэгцээнд	4.60	397.44	Төв, Эрдэнэ, 5-р баг, Тамган	Өөрийн эзэмшлийн талбайд унд, ахуйн зориулалтаар гаргуулсан (107°33'9.56", 47°33'45.08)-аас хангана.
Гүний худаг	Өгөөж их орд ХХК	Унд ахуй	4.80	414.72	Төв, Эрдэнэ, 5-р баг, Тамган	Өөрийн эзэмшлийн талбайд унд, ахуйн зориулалтаар гаргуулсан ("107°33'9.56", 47°33'44.5")-аас хангана.

7. Төсөлд хэрэглэх, ашиглах усны хэмжээ

Төслийн усны хэрэгцээг БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301 дүгээр тушаалаар батлсан "Нэгж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд зарцуулах усны норм" болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлангийн төсөлд үндэслэн тооцоход:

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр	Нормын хэмжээ	Хэмжих нэгж	Хоногийн хүчин чадал	Тайлбар	Усны хэрэглээ, м3/хон	Жилд ажиллах хоног/тоо	Усны хэрэглээ, м3/жил
Хүйтэн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдсон байр, ус халаагууртай, усанд орох онгоцтой орон сууц	150.0	л	43	Ажилчдын усны хэрэглээ (л/хон)	6.44	190	1,224.00
Цагаан тугалга (Гравитацийн баяжуулалт)	4.5	м3	342	70%-ийг эргэлтээр, 30% -ийг нөхөн сэлбэлтээр ашиглана (БОННҮ-ний тайлангийн төсөл, 57 х) м3/тн	1539.00	190	292,410.00
Гудамж, зам талбай	2.0	л	700	Зам, талбайн тоосжилт дарахад ашиглах ус (л/м2)	1.40	15	21.00
10-30 насны мод	50.0	л	50	Мод	2.50	60	150.00

Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний нэр	Нормын хэмжээ	Хэмжих нэгж	Хоногийн хүчин чадал	Тайлбар	Усны хэрэглээ, м3/хон	Жилд ажиллах хоног/тоо	Усны хэрэглээ, м3/жил
				үсалгаанд (л/ш)			

8. Дүгнэлт:

Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах усны хэрэглээ, м3/хон:	**472.04**
Усны боломжит нөөц, м3/хон:	**812.16**
Дүгнэлтийн хариу:	**хүрэлцээтэй**
Дүгнэлт:	**"Зөвгазар элемент" ХХК-ийн хэрэгжүүлэх "Цагаан тугалганы ордыг ил аргаар ашиглах төсөл"-д шаардагдах нийт 472.049,4 м3/хон усны хэрэгцээг өөрийн эзэмшлийн талбайд үнд, ахуйн зориулалтаар гаргуулсан 9.4 л/с (812.16 м3/хон) нийлбэр үндаргатай өрөмдмөл 2 ш худгаас хангахад усны ашиглах боломжит нөөцийн хэмжээ хүрэлцээтэй байна.**

9. Тавих шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:

- Төслийг хэрэгжүүлэхдээ Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2-т заасан: "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоометрээс их, эсхүл энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.12-д заасан ахуулгай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн сав газрын захиргаа, хоногт 50 шоометрээс бага хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид сав газрын захиргааны дүгнэлтийг үндэслэн сум, дүүргийн Засаг дарга олгоно"; 24 дүгээр зүйлийн 24.4-т заасан: "Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ эрүүл мэндийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон жүрмын дагуу ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулсан байна";

- Мөн хуулийн 30 дугаар зүйлийн Ус ашиглагчийн үүрэг, ус ашиглагчид тавигдах шаардлагын ; 30.1.1 дэх хэсэгт заасан: "Ус ашиглах зөвшөөрөл, гэрээнд заасан: хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх"; 30.1.3-т заасан: "Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрөл авах, ашиглалтын явцад гарах бохир усыг хаягдал усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэрлэж, төвлөрсөн ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх, эсхүл шууд зайлуулах"; 30.1.4-т заасан: "Ус авах цэг, газар доорх усны цооног, шугам хоолой бүрийг тоолууржуулах"; 30.1.5-т заасан: "Ус, рашааны нөөц ашигласны болон ус бохирдуулсны төлбөр төлөх"; 30.2.2-т заасан: "Үйл ажиллагаанаас гарах хаягдал ус, рашааныг цэвэрлэх байгууламж барьж ашиглах, эсхүл зайлуулах цэг тогтоолгох"

- Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-т заасан: "Хот, тосгоны өнгө үзэмж, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах, газрыг хамгаалах, нөхөн сэргээх шаардлагын дагуу газар эзэмшигч нь эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувийг ногоон байгууламжтай байлгана" гэсэн заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах;

- Зам, талбай тооссжилт дарах болон ногоон байгууламжийн усалгаанд хур бороony усыг хуримтлуулан ашиглаж, усны нөөцийг хэмнэж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгч "Зөвгазар элемент" ХХК-д зөвлөж байна.

Ирээдүй хойч үедээ усны нөөцөө үлдээхийн төлөө усаа хамгаалья, хуримтлуулья, хамтран ажиллая!

Ашигт малтмал газрын тосны газрын
Кадастрын хэлтэс

ТЗ-ийн өөрчлөлтийн дугаар: MV-020756

Нэр: Урт гозгор

Төрөл: Ашиглалтын тусгай зөвшөөрөл

Статус: Хүчин төгөлдөр

Эзэмшигч: Зөв газар элемент

Талбай /га/: 243.4

Солбицол:

		Уртраг			**Өргөрөг**		
#	#	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд
1	1	107	34	0.11	47	34	7.51
1	2	107	34	0.11	47	35	11.76
1	3	107	33	1.42	47	35	11.76
1	4	107	33	1.42	47	34	7.51

АШИГТ МАЛТМАЛ,
ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 03 сарын 16. өдөр Дугаар Т/45. Улаанбаатар хот

Техник-эдийн засгийн үндэслэл
хүлээн авах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн Т/22-01-14 тоот дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Зөв газар элемент ХХК-ийн MV-020756 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсанд тооцсугай.

2. Хүлээн авсан техник-эдийн засгийн үндэслэлийн үйлдвэрлэлийн нөөцийг бүртгэж, геологийн нөөцөөс хөдөлгөөн хийхийг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

3. Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг техник-эдийн засгийн үндэслэлийн дагуу явуулах зөвшөөрөл олгох, хяналт тавьж ажиллах, техник-эдийн засгийн үндэслэлийг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт тус байгууллагын архивт хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулахыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

4. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан төслийн хүчин чадал, техник, технологид өөрчлөлт орсон, ордын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж байхыг Уул уурхай, судалгааны хэлтэс (С.Энхболд)-т даалгасугай.

5. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших MV-020756 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг, түүнийг хуулсан диск, ЭБМЗ-ийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивт, Уул уурхай, судалгааны хэлтэст тус тус хүлээлгэн өгөхийг Зөв газар элемент ХХК-д даалгасугай.

ДАРГА Л.БАЯРМАНДАЛ

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2022 оны 01 дүгээр сарын 26 № Т/22-01-14 Улаанбаатар хот

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших MV-020756 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцсэн тухай

“Зөв газар элемент” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Ляпислазурь эрдэнэ” ХХК боловсруулсан Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлд Монгол Улсын зөвлөх инженер Г.Сандагдорж зөвлөж, Монгол Улсын зөвлөх инженер Ж.Билэгсайхан шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Техник-эдийн засгийн үндэслэл хэлэлцэх салбар зөвлөлийн хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Энэхүү техник-эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар батлсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник-эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник-эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

2. Техник-эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

3. Техник-эдийн засгийн үндэслэл нь Ерөнхий мэдээлэл, Ил уурхайн олборлолт, Баяжуулах технологи, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, уурхайн хаалт, Уурхайн эдийн засаг, төсөв санхүү гэсэн 7 бүлэг, дүгнэлт, хавсралт материал бүхий 111 хуудас тайлбар бичиг, 12 хавсралт зургуудаас бүрдэж байна.

4. Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордын (ХШ 10-19) MV-020756 тоот тусгай зөвшөөрлийн талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хурлын ХХ-12-02 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2016 оны 12

дугаар сарын 06-ны өдрийн н/06 тоот тушаалаар бодитой (В) зэргээр элсний нөөц 141.98 мян.м^3, элсэн дэх цагаан тугалганы нөөц 56.04 тн, титаны нөөц 2.4 тн, боломжтой (С) зэргээр элсний нөөц 6.24 мян.м^3, элсэн дэх цагаан тугалганы нөөц 1.4 тн, титаны нөөц 0.21 тн, бодитой ба боломжтой (В+С) зэргээр элсний нөөц 148.22 мян.м^3, элсэн дэх цагаан тугалганы нөөц 57.44 тн, титаны нөөц 2.61 тн гэж ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэжээ.

5. Төсөлд ашиглалтын үеийн хаягдалгүй, бохирдлыг 13.13 % буюу 19.42 мян.м^3 байхаар тооцож геологийн бодитой ба боломжтой (В+С) зэргийн нөөцийг үйлдвэрлэлийн магадалсан В' нөөцөд шилжүүлэн тооцсоноор үйлдвэрлэлийн нийт 167.37 мян.м^3 элс, элсэн дэх цагаан тугалганы нөөц 57.32 тн, титаны нөөц 2.6 тн байна. Үйлдвэрлэлийн энэхүү нөөцийг олборлохын тулд 151.69 мян.м^3 хөрс хуулалт хийхээр тооцжээ. Жилд 65.0 мян.м^3 элс олборлох хүчин чадалтайгаар 3 жилийн хугацаанд ажиллахаар төлөвлөжээ.

6. Уурхайн ашиглалтын систем нь авто тээвэртэй, гадаад, дотоод овоолготой ил уурхайн ашиглалтын системээр ашиглахаар төлөвлөжээ.

7. Ил уурхайн хөрс хуулалт, элс олборлолтын ажилд 2.5 м^3-ийн утгуурын багтаамжтай Hitachi ZX-470L-CH маркийн экскаватор 1 ширхэг, 20 тн даацтай HOWO маркийн автосамосвал 2 ширхэг, 3.5 м^3-ийн утгуурын багтаамжтай Komatsu WA430 маркийн утгуурт ачигч 2 ширхэг зэрэг тоног төхөөрөмжүүдийг үндсэн процессуудад ашиглахаар сонгон тооцоолжээ.

8. Баяжуулах үйлдвэрийн баяжуулах технологийг "Зөв газар элемент" ХХК-с өгсөн техникийн даалгавар болон Шинжлэх ухаан академи, Хими, хими технологийн хүрээлэнгийн харьяа Эрдсийн технологийн төвийн лабораторид гүйцэтгэсэн туршилтын үр дүнд үндэслэн урьдчилсан байдлаар сонгосон байна. Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал 65.0 мян.м^3/жил байна. Уг ордын элсийг гравитацын аргаар баяжуулан 61.02 % цагаан тугалганы агуулгатай, 84.27 %-ийн металл авалттай, 0.03 %-ийн гарцтай, 103.07 тн баяжмал үйлдвэрлэхээр тооцсон байна.

9. Уурхайн цахилгаан хэрэглэгчдийг Төв аймгийн Эрдэнэ сумын Өвөр жанчивлан нэртэй амралтын газраас "Гурван төхөм" ХХК-ний алтны шороон орд хүртэл татсан шугамаас салбарлуулан Урт гозгорын цагаан тугалганы уурхай хүртэл 500 м урттай 10 кВ-ын өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам татаж цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгажээ. Ил уурхайн технологийн усны хэрэгцээнд жилд 1.8 мян.м^3, баяжуулах үйлдвэрийн технологийн усны хэрэгцээнд жилд 35.8-62.3 мян.м^3, ажиллагсдын унд ахуйн усны хэрэгцээнд жилд 1.3 мян.м^3 ус хэрэглэхээр төлөвлөжээ. Энэхүү усан хангамжийн хэрэгцээний усыг 1 ширхэг гүний худгаас (5 л/сек) хангахаар тооцоолжээ. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг Улаанбаатар хот хүртэл авто замаар тээвэрлэж БНХАУ-д экспортлохоор төсөлд тусгажээ.

10. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 432.13 сая төгрөг зарцуулахаар тооцоолсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 15.0 сая төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 205.04 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 60.5 сая төгрөг, мониторингийн зардалд 29.21 сая төгрөг, нийгмийн хариуцлагын хүрээнд 24.0 сая төгрөг, дүйцүүлэн хамгаалах зардалд 80.0 сая төгрөг, бусад ажилд 18.38 сая төгрөг тус тус зарцуулахаар төсөлд тусгажээ.

11. Уг төслийг хэрэгжүүлснээр 48 хүн ажлын байраар хангагдах ба уурхайн ажилчдын сарын дундаж цалин 1218.58 мян.төг байхаар байна.

12. Төсөл хэрэгжүүлэхэд нийт 1'379.97 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай байна. Үүнээс бэлтгэл ажлын хөрөнгө оруулалт 141.21 сая төгрөг, ил уурхайн үндсэн техник, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 631.47 сая төгрөг, баяжуулах үйлдвэрийн хөрөнгө оруулалт 146.31 сая төгрөг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт 460.98 сая төгрөг байхаар тус тус тооцжээ. Элэгдэл хорогдлын шимтгэлийн зардалд жилд дунджаар 337.43 сая төгрөг байхаар тооцоолсон байна.

13. Уурхайг ашиглах хугацаанд нийт 5'284.14 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарган, 6'177.37 сая төгрөгийн борлуулалт хийж 1.26 тэрбум төгрөгийн татварын өмнөх ашигтай ажиллахаар байна. Татвар ногдуулсны дараах байдлаар нийт 1.13 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар байна. Улс, орон нутгийн төсөвт 1.23 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ. Уурхайн ашиглалтын хугацаанд нэгж бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 51.27 сая.төг/тн байна.

14. Төсөл хэрэгжих хугацаанд нийт 2.14 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд төслийн өнөөгийн цэвэр үнэ цэнэ (NPV, @10%) 402.51 сая төгрөг, өгөөжийн дотоод норм (IRR) 25.98 %, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа 1.8 жил байхаар тооцжээ.

Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс техник-эдийн засгийн үндэслэлийн захиалагч, боловсруулагч болон төслийн шинжээчид дараах асуудлыг анхааруулж байна.

1. Төсөл захиалагч нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн А/205 тоот тушаалаар батлагдсан Баяжуулах үйлдвэрт тавигдах шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журмын дагуу үйл ажиллагаа явуулахыг анхааруулж байна.
2. Төсөл захиалагчид Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/181, А/458 тоот тушаалаар батлагдсан Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулж холбогдох байгууллагаар хэлэлцүүлэн, уурхайн хаалт, нөхөн сэргээлт хийхийг үүрэг болгож байна.
3. Төсөлд шаардлагатай мэргэжлээр орон нутгийн иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулж байна.
4. Байгаль орчныг хамгаалах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд онцгой анхаарч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөс даалгаж байна.
5. Засгийн газрын 379-р тогтоолоор батлагдсан “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигч компанид анхааруулж байна.
6. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан хангамж, дэд бүтцийн сонголт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шийдлийн талаар төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Ляпислазурь эрдэнэ” ХХК мөн ТЭЗҮ-ийн үнэн бодит байдал, чанарт дүгнэлт гаргасан шинжээч Монгол Улсын зөвлөх инженер Ж.Билэгсайхан тус тус хариуцна.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаас Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн дараах шийдвэр гаргахыг Ашигт малтмал, газрын тосны газрын даргад уламжлахаар тогтов. Үүнд:

1. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших MV-020756 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах;
2. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэйг төсөл хэрэгжүүлэгчид анхааруулах;
3. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших MV-020756 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэл, түүнийг хуулсан диск, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүгнэлтийн хамт Геологийн баримтын төв архивд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх арга хэмжээг авах.

ТАНИЛЦСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Б.ЭЛБЭГЗАЯА

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ч.ЦОГТБААТАР

БОЛОВСРУУЛСАН:
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Э.МӨНХЗОРИГ

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 12 сарын 06 өдөр Дугаар А/06 Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай

Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4. дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 23 дугаар тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 3.1 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуралдааны ХХ-12-02 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших XV-019135, XV-019952 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах “Урт гозгорын хөндий”-н цагаан тугалганы шороон ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүснэгт №1-ийн дагуу хүлээн авсугай.

Хоёр. Хүлээн авсан цагаан тугалганы ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Г.Золсайхан/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь “Урт гозгорын хөндий”-н цагаан тугалганы ордод 2016 онд явуулсан хайгуулын ажлын үр дүнгийн тайланг хээрийн судалгааны анхдагч материал, тайлангийн бичвэр дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны тэмдэглэл, дүгнэлт, тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хүлээлгэн өгөхийг Зэс газар элемент” ХХК /М.Батчулуун/-д даалгасугай.

Үндэсний төвдийн алба ХУУЛБАР ҮНЭН Гарын үсэг: М.Баярмаа 2025 он 06 сар 05 өдөр

ДАРГА Б.БААТАРЦОГТ

10 0501

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

2016 оны 11 дүгээр сарын 10 Улаанбаатар хот

Дугаар: ХХ-12-02

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших XV-019135, XV-019952 тусгай зөвшөөрлийн талбай дахь “Урт гозгорын хөндий”-н цагаан тугалганы шороон ордод 2016 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнг хэлэлцсэн тухай

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших “Урт гозгорын хөндий”-н цагаан тугалганы шороон ордод 2016 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажлын үр дүнгээр геологич Ш.Очирбат, Б.Энхтайван, уулын инженер Ц.Уугангэрэл нарын боловсруулсан тайлан, уг тайлан болон цагаан тугалганы шороон ордын нөөцийн тооцоонд Геологи-минералогийн ухааны доктор /Ph.D/ Г.Дэжидмаагийн хийсэн шинжээчийн дүгнэлтийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцээд, дараах **ДҮГНЭЛТ**-ийг гаргаж байна.

1. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших “Урт гозгор” нэртэй 243.4 га талбай бүхий XV-019135 дугаар тусгай зөвшөөрөл, “Тугалагт” нэртэй 253.93 га талбай бүхий XV-019952 тоот тусгай зөвшөөрлийг 2016 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн АМГ-ын КХ-ийн даргын 210 дугаар шийдвэрээр “Зөв газар элемент” ХХК-д олгосон байна.

Урт гозгорын орд нь Улаанбаатар хотоос зүүн урагш 70 км, Эрдэнэ сумын төвөөс баруун урагш 25 км, Өвөр жанчивлангийн рашаан сувиллаас баруун тийш 7 км-ийн зайд байрладаг.

“Зөв газар элемент” ХХК нь талбайд 2016 онд өөрийн хөрөнгөөр хайгуулын ажлыг гүйцэтгэж, бодитой болон болзомжтой (B+C) зэргээр нөөцийг тогтоож, хайгуулын ажилд 59.11 сая төгрөг зарцуулсан байна.

2. 1969-1971 онд Т.Захай, Л.Ю.Левришенко нар Урт гозгорын хөндийд шороон ордын эрлийн ажлыг гүйцэтгэн, цагаан тугалганы таамаг нөөцийг 220 тн гэж тодорхойлжээ. Улмаар 1977-1980 онд Т.И Редченко, Б.Ивааншаа нар Урт гозгоын хөндийд нэмэлт эрэл, хайгуулын ажлыг гүйцэтгэн, цагаан тугалганы балансын нөөцийг C_2 зэргээр 83.1 тн гэж тооцсон байна.



1

3. “Зөв газар элемент“ ХХК-ий геологичид 2016 онд Урт гозгорын хөндийн доод хэсэгт хийсэн нэмэлт хайгуулын ажлыг 100-200 х 20 м-ийн торын нягтралаар хайгуулын 6 шугаманд 3.1 м-ийн дундаж гүнтэй 54 шурф буюу 170.5 т/м шурф нэвтрэлтийн ажлаар гүйцэтгэж, шороон ордын ашигт давхаргын нөөцийн хүрээний урт 2000 м, дундаж өргөн нь 132 м, хучаасны зузаан 1.1 м, ашигт давхаргын дундаж зузаан 1.2 м, кассетиритын дундаж агуулга 471 г/м^3, цагаан тугалганы нөөц бодитой болон боломжтой (B+C) зэргээр химийн цэврээр 118.8 тн гэж тогтоожээ.

4. “Урт гозгорын хөндий”-н шороон орд нь Жанчивлангийн хүдрийн зангилаанд орших бөгөөд орд нь проловиаль гаралтай голын сэвсгэр хурдсанд хуримтлагдсан, тууз хэлбэрийн энгийн тогтоцтой, ашигт малтмалын тархац суналын дагуу жигд бус, ашигт давхаргын зузаан харьцангуй жигд үзүүлэлттэй, U маягийн хөндийг дагаж хуримтлагдсан маш бага гүнд байрлах III бүлгийн шороон орд юм. Ашигт давхарга нь хөндийн баруун эрэг дагуух орчин үеийн гольдролоор сунаж тогтсон бөгөөд муу мөлгөржсөн хайрга, хайрганцар агуулсан саарал өнгийн элсэнцэр хурдсанд агуулагдах ба ул суурь нь Жанчивлан гүний бүрдлийн цагаан саарал, шар саарал өнгийн өөрчлөгдсөн боржин, боржин-порфир болно.

5. Хайгуулын талбайн 1:2000-ын масштабтай топо зураглалыг “Жеммери сүрвей” ХХК-иар гүйцэтгүүлж, ордын ашигт давхаргын эрдсийн бүрэлдэхүүн, ашигт эрдсийн шигшүүр шинжилгээ, технологийн туршилтыг ШУА-н Эрдэс боловсруулалтын хүрээлэнгийн лабораторит хийлгэжээ. Касситерит дахь цагаан тугалганы агуулгыг 76.81% гэж химийн шинжилгээгээр тодорхойлсон байна.

6. Зохиогчид XV-019135 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах цагаан тугалганы геологийн нөөцийг бодитой (B) зэргээр шлихээр 72.95 тн, химийн цэврээр 56.04 тн, боломжтой (C) зэргээр шлихээр 1.82 тн, химийн цэврээр 1.4 тн гэж, тооцжээ. XV-019952 тоот тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах цагаан тугалганы геологийн нөөцийг бодитой (B) зэргээр шлихээр 34.94 тн, химийн цэврээр 26.84 тн, боломжтой (C) зэргээр шлихээр 6.92 тн, химийн цэврээр 5.32 тн гэж, шлихээр 3.0 тн, химийн цэврээр 2.3 тн баялгийг P_1 зэргээр, орон нутгийн тусгай хамгаалалттай бүсэд бодитой (B) зэргээр шлихээр 38.03 тн, химийн цэврээр 29.21 тн гэж тус тус тооцсон байна. Ордын нөөцийн тооцоог гүйцэтгэхдээ дараах жишиг үзүүлэлтүүдийг баримталжээ. Үүнд:

- Босоо нөөцийг тооцоолох алхам дахь захын агуулга 100 г/м^3
- Ашигт давхаргын хамгийн бага зузаан 0.5 м
- Ашигт давхарга доторхи ядуу агуулгатай хэсэг буюу хоосон хэсгийн хамгийн их зузаан 1.0 м
- Нөөцийн блок дахь үйлдвэрийн хамгийн бага агуулга 250 г/м^3
- Ашигт давхаргын хамгийн бага өргөн 20.0 м

7. Ашигт давхарга нь цэвдэгшилгүй, хучдас болон давхаргат хөрсний ус тогтоогдоогүй байна. Ордын талбайд үйлдвэрлэлийн зориулалтаар 1 гүний худаг өрөмдөж, ашиглалтын бэлэн байдалд оруулсан байна. Усны үндрага 5л/с, тооногийг өрөмдсөн диаметр 219 мм, усны тогтсон түвшин 5.8 м, уст үеийн байрлал I үе 18-19.5м, II үе 47-47.5м, III үе 70-78м учир үндны болон уурхайн усан хангамжийн тус худгаас хангах

Үндэсний геологийн алба
ГЕОЛОГИЙН БАРИМТЫН ТӨВ АРХИВ

2

3

боломжтой байна. Химийн шинжилгээгээр уг худгийн ус нь гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн устай гэж тогтоожээ.

8. Ордын ашигт давхаргын элсний баяжуулах технологийн туршилтыг Эрдэс боловсруулалтын технологийн хүрээлэнгийн лабораторит хийлгэсэн бөгөөд касситеритын ширхэглэлийн ангиллаар +2; -2.0+1.18 мм; -1.18+0.6 мм; -0.6+0.3 мм; -0.3+0.15 мм-ийн ангилалд цагаан тугалганы гарцтай, металлийн тархалтын эзлэх хувь 88% байна. Уг ордын элсийг шлюз бүхий сэгсрэх ширээ хосолсон аргаар баяжуулж, 61.02%-ийн агуулгатай 84.27%-ийн металл авалттай цагаан тугалганы сайн чанарын баяжмал гарган авах боломжтой гэж технологийн туршилт судалгааны үр дүнгээр үзжээ.

9. Ордыг ашиглах техник эдийн засгийн урьдчилсан тооцоогоор ордыг 5 жилийн хугацаанд ашиглах бөгөөд 237.50 мян.м^3 хөрс хуулж, 282.03 мян.м^3 элс угаан, касситеритын баяжмал 120.2 тн үйлдвэрлэнэ. Борлуулалтын нийт орлого 3475.0 сая.төг, нийт зардал 2177.74 сая.төг, 1167.52 сая.төгрөгийн цэвэр ашиг олох ба бэлэн мөнгөний урсгал 2.8 тэрбум төгрөг, 1 тн бүтээгдэхүүний бүрэн өөрийн өртөг 254.05 сая төгрөг байхаар тооцсон байна.

Нийт ашиглалтын хугацаанд байгаль орчныг хамгаалах ажлын зардалд 25.0 сая төгрөг, хаалт нөхөн сэргээлтийн ажлын зардалд 169.8 сая төгрөг тус тус зарцуулахаар төлөвлөжээ.

10. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон ордыг ашиглах ТЭЗҮ-ийг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэх, ТЭЗҮ хийлгэхээс өмнө улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардлын нөхөн төлбөрийн хэмжээг тогтоолгон, ордыг ашиглах эдийн засгийн тооцоонд тусгах, холбогдох хууль тогтоомж, ялангуяа “Ашигт малтмалын тухай” хууль түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан заавар, журмуудыг мөрдөж ажиллахыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид анхааруулахаар тогтов.

Тайлан зохиогчдын илтгэл, тайлбар, шинжээчийн дүгнэлт, Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаас дараах дүгнэлтийг гаргав. Үүнд:

1. “Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших “Урт гозгорын хөндий”-н цагаан тугалганы шороон ордын (ордын нөөц 2016 оны 6 дугаар сарын 15-ны байдлаар) нөөцийг XV-019135 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах цагаан тугалганы геологийн бодитой (B) нөөцийг шлихээр 72.95 тн, химийн цэврээр 56.04 тн, боломжтой (C) нөөцийг шлихээр 1.82 тн, химийн цэврээр 1.4 тн, XV-019952 тоот хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах цагаан тугалганы геологийн бодитой (B) нөөцийг шлихээр 34.94 тн, химийн цэврээр 26.84 тн, боломжтой (C) нөөцийг шлихээр 6.92 тн, химийн цэврээр 5.32 тн гэж зохиогчийн тооцоолсон хувилбараар, хавсралт хүснэгт №1-ийн дагуу хүлээн авах.

2. Хуралдааны энэхүү дүгнэлтийн дагуу хүлээн авсан Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь “Урт гозгорын хөндий”-н цагаан тугалганы шороон ордын XV-019135, XV-019952 тоот хайгуулын тусгай зөвшөөрөлд хамаарах геологийн нөөцийг ашигт малтмалын

Үндэсний геологийн алба
ГЕОЛОГИЙН БАРИМТЫН ТӨВ АРХИВ

нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв (Г.Золсайхан)-д зөвшөөрөх.

3. Энэхүү дүгнэлтийн 10 дугаар заалтыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Зөв газар элемент“ ХХК (М.Батчулуун)-д анхааруулах.

4. Хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, тайлангийн бичвэр диск, хээрийн судалгааны анхдагч материалын хамт ЭБМЗ-ийн хуралдааны энэхүү дүгнэлт, түүний дагуу АМГТГ-ын даргын шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан, Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хүлээлгэн өгохийг “Зөв газар элемент“ ХХК (М.Батчулуун)-д даалгах.

5. Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших “Урт гозгорын хөндий”-н цагаан тугалганы шороон ордод 2016 онд гүйцэтгэсэн нэмэлт хайгуулын ажил, дээжлэлт, тайлан боловсруулалтын ажлын үнэмшил, чанарыг тайлан зохиогч геологич Ш.Очирбат, Б.Энхтайван, уулын инженер Ц.Уугангэрэл нар, шлихийн дээжийн боловсруулалт, жигнэлтийг ГТЛ, технологийн туршилтыг ШУА-ын Эрдэс боловсруулалтын хүрээлэнгийн лаборатори, 1:2000-ны масштабын топо зураглалын ажлыг “Жеммери сүрвей” ХХК тус тус хариуцах, дээрх гүйцэтгэсэн ажлуудын үнэн бодит байдал, чанарыг хянаж гаргасан дүгнэлтийг МУ-ын зөвлөх инженер, доктор Г.Дэжидмаа болон “Зөв газар элемент“ ХХК хариуцах.

ТАНИЛЦСАН:
ЭБМЗ-ИЙН ДАРГА Б.БААТАРЦОГТ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:
ЭБМЗ-ИЙН ГИШҮҮН,
УУХҮЯ-НЫ ГЕОЛОГИЙН БОДЛОГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ГАНБАТ

БОЛОВСРУУЛСАН:
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.ОЮУНЦЭЦЭГ

Үндэсний геологийн алба
ГЕОЛОГИЙН БАРИМТЫН ТӨВ
АРХИВ

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт "Өгөөж их орд" ХХК-ийн MV-020756 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Урт гозгорын хөндийн цагаан тугалганы шороон ордыг (ХШ 10-19) ил аргаар ашиглах төслийн ашиглалтын 5 жилийн БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам", мөн сайдын 2014 оны А-117 тоот тушаалаар батлагдсан үнэлгээ хийх аргачлалыг баримтлан боловсруулсан болно.

Хүснэгт 1. БОМТ-г хэрэгжүүлэх арга хэмжээний нийт зардал

№	Ажлын нэр	Зардал / төг/				
		2026	2027	2028	2029	2030
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	66,557.0	32,657.0	27,407.0		
2	Нөхөн сэргээлт, хаалтын зардал		35,000.0	-	562,110.0	-
3	Дүйцүүлэн хамгаалах биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний зардал	15,000.00	15,000.00	15,000.00	39,500.00	24,500.00
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5,425.00	3,675.00	3,675.00	-	-
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3,500.00	-	-	-	-
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	17,680,0	17,680,0	17,680,0	-	-
7	Удирдлага зохион байгуулалт	10,000.0	10,000.00	-	-	-
8	Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх	-	-	-	-	-
Нийт		**1,004,608.0**				